

Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2012 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын тайлан

## Үл хөдлөх эд хөрөнгө, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүх төрлийн албан татвар ногдуулалт, хураалтын бодлого, үр дүн

**НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР**

**Аудит хийх үндэслэл:** Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрх, ҮАГ, Нийслэлийн аудитын газрын 2012 оны бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөг үндэслэн хийв

**Аудитын ерөнхий дүгнэлт:**  
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэл хангалтгүйгээс албан татварын ногдуулалт, хураалтыг бүрэн хийдэггүй байна.

**Аудитын нэр**  
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүх төрлийн албан татварын ногдуулалт хураалтын бодлого үр дүн

Улаанбаатар хот  
2012 он

**НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР**

**Нийслэлийн Аудитын газрын төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан**

УБЕГ, УТЕГ, татварын албад улсын бүртгэлд бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгийг үнэн зөв бүртгээгүй, зохих хяналтыг таснаггүйгээс шалтгаалж 4.2 тэрбум төгрөгийн албан татварыг ногдуулаагүй байна.

**Нийслэл, дүүргийн Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын бүртгэл, ногдуулалт, хураалтын үр дүн**

Улаанбаатар хот  
2012 он

НАГ-АХ-20121-02-ГА

**Хөрөнгийн бүртгэл хариуцсан болон татварын орлого бүрдүүлэгч байгууллагын ажлын уялдаа хангалтгүй байна**

## Агуулга

<b>Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар</b>	<b>Агуулга</b> ..... 1
<i>Захирал</i> <i>Д.Ганбилэг</i>	<b>Товчилсон үгийн жагсаалт</b> ..... 3
<i>Аудитын менежер</i> <i>Х.Баярмаа</i>	<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл</b> ..... 4
<i>V багийн Ахлах шинжээч</i> <i>Л.Эрдэнэчулуун</i>	<b>Бүлэг 1. Үл хөдлөх эд хөрөнгө, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын бодлого, зохицуулалт үр нөлөөтэй хэрэгжихгүй байна</b>
<i>Аудитор</i> <i>З.Ариунзаяа</i>	<b>Ерөнхий зүйл</b> ..... 5
<i>Шинжээч</i> <i>Б.Саруул</i> <i>Ш.Энхтайван</i> <i>Д.Энхболд</i>	▪ Хөрөнгийн бүртгэл хариуцсан болон татварын орлого бүрдүүлэгч байгууллага хоорондын ажлын уялдаа хангалтгүй байна ..... 5
<i>НЕА-ын орлогч</i> <i>Т.Сарантуяа</i>	▪ Нийслэл, орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх нөөцийг бүрэн ашиглахгүй байна ..... 7
<i>ГА-ын менежер</i> <i>А.Цогбаяр</i>	<b>Бүлэг 2. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна</b>
<i>Нийслэлийн аудитын газрын гүйцэтгэлийн аудитын I, III баг</i>	<b>Оршил</b> ..... 9
	▪ ЭХЭУБХ-ийн мэдээллийн сан дахь мэдээлэл үнэн зөв бүртгэгдээгүй, үнэлгээ нь зөрүүтэй байна..... 9
	▪ Үл хөдлөх эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн санг бүрэн бүрдүүлээгүй байна ..... 10
	▪ Хуулийн дагуу дүрэм журмууд бүрэн батлагдаагүйгээс зарим үйл ажиллагаа зохицуулалтгүй үлджээ ..... 10
	▪ Улсын бүртгэлийн ерөнхий газрын дотоод бүтцийн нэгжүүд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс үнэн зөв, бодит мэдээллийг харилцагчдад өгч чадахгүй байна ..... 10
	▪ Улсын бүртгэлийн ерөнхий газрын дүүргүүд дэх салбарын мэдээллийн аюулгүй байдал алдагдахад хүрчээ ..... 11
	▪ ААНБ, иргэдэд ажил, үйлчилгээг хөнгөн, шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх зохистой арга хэмжээг авч ажиллахгүй байна ..... 12
	▪ УБЕГ-аас ирүүлж байгаа мэдээлэл хангалтгүйгээс татвар ногдуулалт бүрэн хэрэгжихгүй байна ..... 12
	▪ ҮХЭХАТТухай хуулийн дагуу мөрдөх дүрэм журам бүрэн гараагүй, эрх зүйн зохицуулалт бүрдээгүй байна ..... 13
<b>2012 оны 6 дугаар сар</b>	
<b>Уг тайланг ҮАГ-ын Веб сайт- аас үзнэ үү. <a href="http://www.mnao.mn">www.mnao.mn</a></b>	
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885, 263755, 261805 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	
<b>ХАЯГ:</b> <i>Үндэсний аудитын газар Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр Улаанбаатар хот 15160 Монгол улс</i>	

- ЭХЭУБГ, НГА үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс 7895 иргэний ҮХЭХ-ийг татварын бүртгэл мэдээллийн санд бүртгээгүй байна ..... 14
- Бүртгэлгүй, үнэлгээний зөрүүтэй үл хөдлөх эд хөрөнгө, иргэдийн өмчилсөн газарт 4260.8 сая төгрөгийн албан татварын ногдуулалт хийгдээгүй байна..... 15
- ҮХЭХАТ-ын ногдуулалт, төвлөрүүлэлтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна ..... 16
- 2011 онд ногдуулсан ҮХЭХАТ-аас 2.5 тэрбум төгрөгийг хугацаанд нь бүрэн төвлөрүүлээгүй байна ..... 17

**Бүлэг 3. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг бүрэн хурааж чадахгүй байна** ..... 18

- Оршил ..... 18
- АТБӨЯХАТ-ыг хураах байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна ..... 18
- ААНБ, иргэдэд үзүүлэх үйлчилгээ ихээхэн хүндрэлтэй, цаг хугацаа их шаардаж байна..... 20
- АТГ АТБӨЯХ-ийн улсын бүртгэлийг ангиллын дагуу бүрэн гүйцэд хөтлөөгүй байна ..... 20
- Татварын албад АТБӨЯХ-ийн 84466 албан татвар төлөгчийг үнэн зөв бүртгээгүй байна ..... 21
- АТБӨЯХ-ийг зөрүүтэй бүртгэснээс 88613 тээврийн хэрэгсэлд 2900.7 сая төгрөгийн татвар дутуу ногдуулсан байна ..... 22
- 3972.9 сая төгрөгийн албан татварыг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна ..... 23

Дүгнэлт ..... 24

Зөвлөмж ..... 38

**ХАВСРАЛТ:**

- Хавсралт №1 ..... 38

## Товчилсон үгийн жагсаалт

<b>ААНБ</b>	Аж ахуйн нэгж, байгууллага
<b>АБТ</b>	Агаарын бохирдлын төлбөр
<b>АТБӨЯХАТ</b>	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
<b>АТБӨЯХ</b>	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл
<b>АТБӨЯХАТТХ</b>	Автотээврийн хэрэгсэл болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль
<b>АТТХ</b>	Авто тээврийн тухай хууль
<b>БГД</b>	Баянгол дүүрэг
<b>БЗД</b>	Баянзүрх дүүрэг
<b>БНД</b>	Багануур дүүрэг
<b>БХГ</b>	Багахангай дүүрэг
<b>ГЕГ</b>	Гаалийн ерөнхий газар
<b>ЗТБХБС</b>	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
<b>ЗЦГ</b>	Замын цагдаагийн газар
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
<b>НАГ</b>	Нийслэлийн аудитын газар
<b>НГА</b>	Нийслэлийн газрын алба
<b>НЗД</b>	Нийслэлийн Засаг дарга
<b>НИТХ</b>	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
<b>СБД</b>	Сүхбаатар дүүрэг
<b>СХД</b>	Сонгинохайрхан дүүрэг
<b>ТЕГ</b>	Татварын ерөнхий газар
<b>ТЕХ</b>	Татварын ерөнхий хууль
<b>ТХОХЗА</b>	Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт зохицуулалтын алба
<b>УБЕГ</b>	Улсын бүртгэлийн ерөнхий газар
<b>УБЕХ</b>	Улсын бүртгэлийн ерөнхий хууль
<b>ҮАГ</b>	Үндэсний аудитын газар
<b>ҮХЭХАТТХ</b>	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль
<b>ҮТЕГ</b>	Үндэсний татварын ерөнхий газар /хуучин нэрээр/
<b>ҮХЭХАТ</b>	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
<b>ҮХЭХ</b>	Үл хөдлөх эд хөрөнгө
<b>ХЗДХС</b>	Хууль зүй, дотоод хэргийн сайд
<b>ХЗДХЯ</b>	Хууль зүй, дотоод хэргийн яам
<b>ХУД</b>	Хан-Уул дүүрэг
<b>ЭХЭУБГ</b>	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар /хуучин нэрээр/
<b>ЭХЭУБХ</b>	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хэлтэс
<b>ЭХӨЭТХЭХБЭУБТХ</b>	Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль

## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаархи мэдэгдэл**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2012 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

### **Аудитын зорилт**

Үл хөдлөх эд хөрөнгө, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүх төрлийн албан татвар ногдуулалт, хураалтын бодлого, үр дүнг шалган дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд доорх чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Үл хөдлөх эд хөрөнгө, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүх төрлийн албан татварын бодлого, зохицуулалт оновчтой эсэх,
- Үл хөдлөх эд хөрөнгө, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэл, албан татварын ногдуулалт, хураалтын ажил, үйлчилгээ үр дүнтэй эсэх.

### **Хамарсан хүрээ**

Аудитад үл хөдлөх эд хөрөнгө, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүх төрлийн албан татварын бодлого боловсруулагч төрийн захиргааны төв байгууллага Сангийн, Хууль зүй, дотоод хэргийн, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамд болон Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Автотээврийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Цагдаагийн ерөнхий газар, мөн нийслэл, дүүргийн татварын албад, Замын цагдаагийн тасаг хамрагдлаа.

### **Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл**

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Холбогдох албан тушаалтантай ярилцаж, тодруулга, лавлагаа авах, тоон мэдээлэл гаргуулан судалгаа хийх, хэрэгжүүлэгч байгууллагын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлийг үнэлэх,
- Аудитын хөтөлбөр, арга зүй, горимын дагуу цуглуулсан баримт материал, нотлох зүйлд дүн шинжилгээ хийх, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрчлэн шалгах, мэдээллийн эх үүсвэртэй тулган баталгаажуулах,
- Нарийвчилсан төлөвлөгөө гарган хөтөлбөр, горимыг хэрэгжүүлэх.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитыг ҮАГ-ын ГАГ-ын V баг, Нийслэлийн аудитын газрын гүйцэтгэлийн аудитын I, III багууд хамтран гүйцэтгэв.

## Бүлэг 1. Үл хөдлөх эд хөрөнгө, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын бодлого, зохицуулалт үр нөлөөтэй хэрэгжихгүй байна

### Ерөнхий зүйл

1.1 Монгол Улсын “Татварын ерөнхий хууль”-ийн 7.4-т зааснаар “Үл хөдлөх эд хөрөнгө” (цаашид “ҮХЭХ” гэх), “Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл” (цаашид “АТБӨЯХ” гэх)-ийн албан татвар нь эрх олгосноор аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хувь хэмжээг нь тогтоож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, эсхүл тухайн нутаг дэвсгэрт үйлчлэх, орон нутгийн татварт хамаарна.


1.2 Хөрөнгө эзэмшигчийг тогтоох, бүртгэж баталгаажуулах, мэдээллээр хангах болон харилцан солилцох, татвар төлөгчийг бүртгэж татвар ногдуулах, хураах үйл ажиллагааг ТЕГ, ГЕГ, АТГ, УБЕГ зэрэг Засгийн газрын агентлаг болон тэдгээр асуудлыг хариуцсан төрийн захиргааны байгууллагууд хариуцан гүйцэтгэж байна.

### Хөрөнгийн бүртгэл хариуцсан болон татварын орлого бүрдүүлэгч байгууллагын ажлын уялдаа хангалтгүй байна

1.3 Татварын хуулийн хэрэгжилтийг жигд хангах, зүй зохистой явуулах, нийслэл, /орон нутаг/-ийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх нэг нөхцөл нь хөрөнгийн бүртгэл хариуцсан байгууллага болох УБЕГ, АТГ-аас гаргаж ирүүлэх албан ёсны бүртгэл, мэдээлэлд үндэслэн хөрөнгө эзэмшигчийг тогтоосон үнэн зөв, найдвартай мэдээллийн баазад суурилсан татварын бүртгэл юм. /Схем №1/

Схем №1

#### ҮХЭХ, АТБӨЯХ-ИЙН ТАТВАР БҮРДҮҮЛЭЛТИЙН ОРЧИН-МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛ



1.4 ТЕГ, түүний харъяа нийслэл, дүүргийн татварын албад өөрсдийн нөөц бололцоонд суурилан татвар ногдуулж, хураан барагдуулж зохих түвшинд татварын орлогыг төсөвт төвлөрүүлж байгаа боловч хариуцагч байгууллагуудын мэдээллийн технологийн түвшин, хурд харилцан адилгүй, төрийн байгууллагуудын нэгдсэн мэдээлэл, технологийн бодлогогүй, татварын орчинг бий болгох үндсэн мэдээллийн баазын бүрдэлт хангалтгүй байна.

1.5 Төрийн байгууллагууд мэдээллээ тодорхой хугацаанд файл хэлбэрийн мэдээллийн баазаар солилцож эхэлсэн нь мэдээллийг цаасан хэлбэрээр дамжуулдаг байсан үеэс дэвшилттэй ч мэдээллийн технологийн түвшин, чадвар сул, мэдээллийн технологийг хариуцаж буй хүмүүсээс хараат байгаа буюу өөрөөр хэлбэл мэдээлэл ашиглалт, боловсруулалт өнөөгийн шаардлагад хүрэхгүй байна.

1.6 Энэхүү 2 төрлийн татварын орчны хууль болон түүний үйлчлэх хүрээнд холбогдох байгууллагуудаас гарган мөрдүүлж байгаа эрх зүйн актын зарим заалтын хэрэгжилт жигд бус, оролцож буй байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо хангалтгүй байна.<sup>1</sup>

1.7 АТБӨЯХАТ-ыг төлсөн эсэхэд тавих хяналтыг сайжруулахын тулд “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хуульд өөрчлөлт оруулсны үндсэн дээр Замын цагдаагийн алба, Татварын албатай хамтарч хэрэгжүүлэх үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлж ажиллах шаардлагатай байна.

1.8 Хувийн хэвшил давамгайлсан эдийн засагт татвар төлөгч аж ахуйн нэгж, иргэний хөрөнгө өмчлөх, эзэмших явдал өсөн нэмэгдэж байгаа учраас хууль эрх зүйн болон практик шаардлагад үндэслэн аливаа зохицуулалтыг хийх, байгууллагуудын оролцоо, үүргийг албажуулах хэрэгтэй байна.

1.9 УБЕГ ҮХЭХ-ийн эзэмшигчийн тоо, бүртгүүлсэн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний нийт дүн, хөрөнгийн тоог улсын хэмжээнд болон аймаг, нийслэл гэсэн ангиллаар гаргаж чадаагүй бөгөөд энэ нь хэд хэдэн хүн нэг үл хөдлөх хөрөнгийг хамтран эзэмшигч байдаг тул мэдээллийн сангаас ялган гаргах бололцоогүйтэй холбоотой гэж тайлбарласан.

1.10 ГЕГ-аас авсан АТБӨЯХ-ийн импортын мэдээг АТГ-ын бүртгэл мэдээлэлтэй тулган үзэхэд 55851 тээврийн хэрэгсэл бүртгэгдээгүй, 66259 тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн багтаамж, даац тодорхойгүй байсан тул тодруулахаар АТГ-т хандахад ЗЦГ-аас шилжүүлэн авахдаа мэдээллийн санг бүрэн бүрдүүлж чадаагүй тул боломжгүй, энэ талаар одоо ажиллаж байна гэсэн хариу өгчээ.

1.11 Дээрхээс үзэхэд УБЕГ болон АТГ-ын бүртгэлийн мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт, ТЕГ-тай хийх мэдээллийн солилцоо хангалтгүй, бодитой биш байна гэж дүгнэж болохоор байна.

**Нийслэл, орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх нөөцийг бүрэн ашиглахгүй байна**

<sup>1</sup> - *Автомтээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2,*

*- Агаарын бохирдлын тухай хуулийн 9.3,*

*- Монгол Улсын Тэргүүн шадар сайд, Сангийн сайдын хамтарсан 2010 оны “Журам батлах тухай” 04/07 дугаар тушаал,*

*- Монгол Улсын Засгийн газрын 2009 оны “Автомтээврийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 251 дүгээр тогтоол,*

*- Татварын ерөнхий газрын дарга, Авто тээврийн газрын дарга нарын 2011 оны “Мэдээлэл солилцох тухай гэрээ”,*

*- Авто тээврийн газрын дарга, Татварын ерөнхий газрын дарга нарын 2010 оны “Хамтран ажиллах гэрээ”*

*- Татварын ерөнхий газрын даргын 2011 оны 436 дугаар тушаал,*

*- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 121 дүгээр тогтоол*

*- УТЕГ-ын даргын 2009 оны 11 дүгээр сарын 24-ний 527 дугаар тушаалаар баталсан “Татвар төлөгчийг бүртгэх журам”*

1.12 Татварын байгууллагаас улс, орон нутгийн төсөвт 2011 онд 2.1 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх 2 онтой зэрэгцүүлэхэд өссөн бөгөөд тэдгээрт АТБӨЯХАТ-ын орлого 0.9 хувь, АБТ 0.04 хувь, ҮХЭХАТ-ын орлого 0.8 хувийг эзэлж байна. /Хүснэгт №1/

Хүснэгт №1

ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ТОО, ХУРААЛТ\*

ҮЗҮҮЛЭЛТ (Татварын төрлөөр/)	2009 он		2010 он		2011 он	
	тоо	хураалтын дүн	тоо	хураалтын дүн	тоо	хураалтын дүн
<b>Улсын төсөвт нийт төвлөрүүлсэн орлого</b>	<b>515 489</b>	<b>938 104.0</b>	<b>453 558</b>	<b>1 543 977.9</b>	<b>598 730</b>	<b>2 117 326.7</b>
Үүнээс, АТБӨЯХАТ татвар	190 844	9 049.5	207 418	10 274.4	229 971	18 757.0
АБТөлбөр					96 841	795.6
ҮХЭХ-ийн татвар	22 524	11 096.0	28 191	13 662.1	34 295	17 088.5
<b>Нийслэлийн төсөвт нийт төвлөрүүлсэн орлого</b>	<b>180 808</b>	<b>106 151.7</b>	<b>199 572</b>	<b>163 431.8</b>	<b>268 344</b>	<b>216 117.5</b>
Үүнээс, АТБӨЯХАТ татвар	148 152	5 494.7	160 145	5 946.0	208 543	10 751.3
АБТөлбөр					-	377.9
ҮХЭХ-ийн татвар	9 732	6 733.5	9 443	8 653.2	9 784	10 371.5

\*Эх сурвалж: Татварын ерөнхий газар, Нийслэлийн татварын газар, Нийслэлийн аудитын газар

1.13 Хөрөнгө эзэмшигч болон өмчлөгч хуулийн этгээд буюу АТБӨЯХ, ҮХЭХ-ийн албан татвар ногдуулах татвар төлөгчдийн дийлэнх нь нийслэлд төвлөрч байна.

1.14 Нийслэлийн хэмжээнд нийт 216.1 тэрбум төгрөгийн татварын орлогыг төсөвт төвлөрүүлсэн ба тэдгээрт АТБӨЯХАТ 4.9 хувь, ҮХЭХАТ 4.8 хувийг тус тус эзэлж байна.

1.15 АТБӨЯХАТ-ын ногдуулалт улсын хэмжээнд 2010 онд өмнөх оноос 16574, 2011 онд 22553, нийслэлийн хэмжээнд 2010 онд 13283, 2011 онд 50148 нэгжээр тус тус өссөн байна.

1.16 ҮХЭХАТ төлөгчдийн тоо улсын хэмжээнд өссөн байхад, харин нийслэлийн хэмжээнд 2010 онд өмнөх оноос 289 нэгжээр буурсан, 2011 онд 341 нэгжээр нэмэгдсэн нь энэ төрлийн татвар төлөгчдийн анхан шатны болон шилжилт, хөдөлгөөний бүртгэл, түүнд тавих хяналт сул байгаатай холбоотой юм.

1.17 Татварын ерөнхий хуулийн 7.3.13-ын дагуу АБТ-ийг улсын төсөвт төвлөрүүлж байгаа бөгөөд уг төлбөрийг тухайн бүс нутаг /нийслэл/-т төвлөрүүлэн хэрэгцээт арга хэмжээнд нь зарцуулах нь зохимжтой гэж үзэж байна.

1.18 Улсын хэмжээнд импортоор оруулж байгаа тээврийн хэрэгслийн тоо жигд өсөлттэй, түүнтэй уялдан улсын төсөвт төвлөрүүлэх гаалийн орлогын хэмжээ сүүлийн 3 жилд тасралтгүй өссөн байна. /Хүснэгт №2/



Хүснэгт №2

**АВТО ТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН ТОО ХЭМЖЭЭ, ТАТВАРЫН МЭДЭЭ\***

/тоо, сая төгрөг/

Он	Тоо хэмжээ	Гаалийн татвар	Онцгой татвар	НӨАТ	Нийт татварийн дүн	Улсын төсөвт төвлөрүүлсэн гаалийн орлого
2009	32 665	10 138,9	26 827,0	23 830,9	60 796,7	515 427,0
2010	70 006	27 725,1	54 277,3	63 608,3	145 610,6	877 644,7
2011	151 120	76 838,2	112 369,7	173 202,7	362 410,6	1 405 815,8

\*Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

1.19 Улсын хилээр оруулж ирсэн тээврийн хэрэгслийн тоо 2010 онд өмнөх онтой зэрэгцүүлбэл 37341-ээр, 2011 онд 81114-өөр тус тус нэмэгдсэн байна.

1.20 Хүснэгт №1, №2-оос үзэхэд албан татварын төрөл болон хөрөнгө эзэмшигчид, улсын хилээр оруулж байгаа тээврийн хэрэгслийн тоо сүүлийн 3 жилд өссөн нь бүртгэлийг чанаржуулах, мэдээллийн бааз, харилцан мэдээлэл солилцох цахим технологийн орчныг сайжруулах, түүнд үндэслэн татвар ногдуулалт, хураалтыг цаг хугацаанд нь үр нөлөөтэй хийж нийслэл, орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх ихээхэн нөөц бололцоо байгаа нь ажиглагдаж байна.

1.21 Улсын хилээр оруулж буй тээврийн хэрэгслийн тоо хэмжээний өсөлттэй АТБӨЯХАТ ногдуулсан тээврийн хэрэгслийн тоог харьцуулахад ихээхэн зөрүүтэй байгаа нь бүртгэл цаг хугацаандаа хийгдээгүй, ГЕГ, АТГ хоорондын мэдээлэл солилцоо, тэдгээрийн ашиглалт хангалтгүй байгааг харуулж байна.

## Бүлэг 2. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна

### Оршил

2.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар нь орон нутгийн төсвийн орлогын бүрдэл хэсэг бөгөөд Татварын ерөнхий хуулиас гадна уг төрлийн албан татварыг 2000 оны 11 дүгээр сарын 17-нд баталсан “Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай”, 2009 оны 6 дугаар сарын 25-ны өдөр баталсан “Улсын бүртгэлийн ерөнхий хууль”-иар тус тус зохицуулж байна.

2.2 ҮХЭХАТТухай хуулийн 5.1-д "Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг уул хөрөнгийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй бол хөрөнгийн даатгалд даатгуулсан үнийн дүнгээр, хөрөнгийн даатгалд даатгуулаагүй бол данс бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр тус тус тодорхойлно", Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 15.8-д "Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын бүртгэлийн тоон мэдээг Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад улирал бүр гаргаж өгнө" гэж заасан байна.



### ЭХЭУБХ-ийн мэдээллийн сан дахь мэдээлэл үнэн зөв бүртгэгдээгүй, үнэлгээ нь зөрүүтэй байна

2.3 Монгол Улсын хэмжээнд үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэх үйл ажиллагааг УБЕГ хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.4 УБЕГ-ын ЭХЭУБХ-ийн бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгийн байршил, зориулалт тодорхой биш, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг бичээгүй, баазад бүртгэсэн үнэлгээ, тухайн үл хөдлөх эд хөрөнгийн мэдүүлгийн үнэлгээнүүд хоорондоо зөрүүтэй, өмчлөгч ААНБ, иргэдийн регистрийн дугаарыг буруу бичсэн зэрэг зөрчлүүд илрэв. Тухайлбал:

- 2009-2011 онуудад ЭХЭУБХ-ийн бүртгэлийн мэдээллийн санд 153 ААНБ, иргэний үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг 7598.2 тэрбум төгрөгөөр бүртгэсэн байв. Гэтэл тэдгээр үл хөдлөх эд хөрөнгийг хувийн хэрэгтэй нь тулгахад 188.5 тэрбум төгрөгийн үнэлгээтэй байна. Мэдээллийн санд эд хөрөнгийн хувийн хэргийн үнэлгээг даруй 7409.7 тэрбум төгрөгийн өндөр үнээр хий бүртгэжээ.

2.5 Эдгээр нь Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгтэй шууд холбоотой УБЕХ-ийн доорх заалтыг зөрчжээ:

- 8.12-ын “бүх шатны бүртгэлийн байгууллага, улсын бүртгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах”,
- Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 3.1.4-ийн “үнэн зөв бодитой”,

- 3.1.5 “нотлох баримтад үндэслэж, хуульд заасан журмын дагуу хөтлөх”,
- ЭХЭУБХ-ийн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаа нь ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 17.1.6-д заасан “Үл хөдлөх эд хөрөнгийн үнэ” тухайн үл хөдлөх эд хөрөнгө шинээр бий болсон бол өмчлөгчийн тодорхойлсон үнэ, өмчлөх эрх шилжиж байгаа бол өмчлөх эрх шилжих болсон хэлцэл, бусад баримт бичигт тусгагдсан үнэ”, 8.1.7-ийн “улсын бүртгэлийн хөтлөлт, эх нотлох баримтын үнэн зөвийг нягтлан бүрдлийг хангах, илэрсэн дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах замаар улсын бүртгэлийн үнэн зөв, бодит байдлыг хангах”,
- 5.1.2-ын “бүртгэл үнэн зөв байх”,
- Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын дэд дарга бөгөөд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын ерөнхий бүртгэгчийн 2004 оны 9 дүгээр тушаалаар баталсан “Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд мэдээлэл оруулах, мэдээллийг боловсруулах, хадгалах журам”-ын 3.2.2-ын “мэдээллийг үнэн зөв оруулна” гэсэн заалтууд тус тус хангагдахгүй байна.

### **Үл хөдлөх эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн санг бүрэн бүрдүүлээгүй байна**

2.6 Мэдээллийн сангийн "Триада" программ хоцрогдсон, программыг шинэчлэх ажлыг 2009 оноос эхлэн "Мянганы сорилын сан"-тай хамтран хэрэгжүүлж эхэлсэн ч удаашралтай байгаагаас мэдээллийн сангийн бүрдэлт хангалтгүй байна.

2.7 Зөвхөн 2001 оноос хойшхи бүртгэлийн мэдээлэл цахим мэдээллийн санд орсон ба мэдээлэл боловсруулалт, баяжуулалт хангалтгүй байна. Тухайлбал, анхны болон сүүлчийн өмчлөгчийн мэдээллийг л авах боломжтой ба дундах өөрчлөлтийн талаарх мэдээллийг авах бололцоогүй байна.

### **Хуулийн дагуу дүрэм журмууд бүрэн батлагдаагүйгээс зарим үйл ажиллагаа зохицуулалтгүй үлджээ**

2.8 УБЕХ-ийн 7.3-т улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүрмийг Засгийн газар батална гэж заасан боловч өнөөгийн байдлаар дүрэм эцэслэн батлагдаагүй, УБЕГ-ын үйл ажиллагаа зохицуулалтгүй явж байна.

2.9 Мөн хуулийн 7.5-д заасан улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь салбар, нэгж, ажилтны бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэхэд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг дарга дэмжлэг үзүүлнэ гэж заасан ч чухам ямар дэмжлэг үзүүлэх нь тодорхойгүй байна.

2.10 ЭХӨЭТХЭХБЭУБТухай хуулийн 18.2-т бүртгэлийн гэрчилгээнд ерөнхий болон улсын бүртгэгч, орон нутагт улсын бүртгэгч гарын үсэг зурж, тэмдэг дарна гэж заасан боловч бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотой УБ хот дахь бүртгэлийн үйл ажиллагаа дүүргүүдэд шилжсэнээр бүртгэлийн гэрчилгээний баталгаажуулалт УБЕГ-т төвлөрч цаг хугацаа их орж, чирэгдэл бий болгож буйг зохицуулах шаардлагатай байна.

### **УБЕГ-ын дотоод бүтцийн нэгжүүд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс үнэн зөв, бодит мэдээллийг харилцагчдад өгч чадахгүй байна**

2.11 УБЕХ-ийн 15.8-д улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын бүртгэлийн тоон мэдээг Үндэсний статистикийн хороо, Төв банк, Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад улирал бүр гаргаж өгнө гэж заасан.

2.12 Энэхүү заалтыг хэрэгжүүлэх үүднээс ХЗДХС-ын 2007 оны 99 дүгээр тушаалаар “Мэдээллийн нэгдсэн сүлжээ болон толгой компьютерийг ашиглах, түүний нууцыг хадгалах, хамгаалах журам”, “Мэдээлэл солилцох жагсаалт”-ыг тус тус баталжээ.

2.13 Дээрх журам болон Тэргүүн шадар сайд, Сангийн сайдын 2010 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 04/07 тушаалаар батлагдсан мэдээлэл солилцох журмын дагуу ТЕГ-тай мэдээлэл солилцож байна.

2.14 Бусад байгууллагуудтай мэдээлэл солилцох ажлыг журамлан хэрэгжүүлж байгаа хэдий ч Улсын бүртгэлийн ерөнхий газрын нэгж, газрууд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2012 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/64 дугаар тушаалаар батлагдсан чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа эрхлэхгүй байна.

2.15 Тухайлбал, дээрх тушаалд УБЕГ-ын ЭХЭУБХ нь улсын хэмжээний бүртгэлийн мэдээ, тайланг нэгтгэн гаргах болон хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой ч өнөөгийн байдлаар энэ асуудлыг хариуцаж ажиллах орон тоо, мэргэжилтэн байхгүй гэсэн шалтгаанаар энэ үүргийг Мэдээллийн технологийн газар нь хариуцан гүйцэтгэж байна.

2.16 Цахим мэдээллийн сан бүрэн бүрдээгүйгээс холбогдох байгууллагуудад үнэн зөв, бодитой мэдээлэл гаргаж өгч чадахгүй, мэдээллийн сангийн баяжилтийг цаг тухайд нь бүрэн хийхгүй, улсын бүртгэгч мэдээллийн санд өгөгдлийг алдаатай оруулах тохиолдол гарч байгаа бөгөөд энэ талаархи УБЕГ-ын Бүртгэл, хяналтын газрын хяналт сул байна.

2.17 УБЕГ-ын даргын 2011 оны 630 дугаар тушаалаар батлагдсан “Улсын бүртгэгчийг бэлтгэх, улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчийг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах журам”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.18 Энэ нь УБЕХ-ийн 11 дүгээр зүйлийн "Улсын бүртгэгч, түүний эрх, үүрэг"-ийг тодорхойлсон 11.3-т “дээд боловсролтой, улсын бүртгэгч бэлтгэх сургалтад хамрагдсан Монгол Улсын иргэнийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, улсын бүртгэгчээр томилж ажиллуулна” гэж заасныг зөрчжээ.

**УБЕГ-ын зарим дүүрэг дэх салбарын мэдээллийн аюулгүй байдал алдагдахад хүрч болзошгүй байна**

2.19 Улсын бүртгэлийн эх нотлох баримтын архив болон цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, төрөлжүүлэн хадгалах, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдал хангалтгүй байна.

2.20 УБЕГ-ын дүүргүүдийн бүртгэлийн архив зориулалтын бус орц, байрны хонгилд, архив нь бүртгэлийн газраас өөр газарт байрласнаас материалыг зөөвөрлөх, архивд орж ажиллах бүртгэгчдийг хянах байдал суларч, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал алдагдахад хүрч болзошгүй байна.

2.21 Бүртгэлийн газар, Бүртгэлийн архивын газрын ажлын уялдаа хангалтгүйгээс үйлчлүүлэгчдэд чирэгдэл учруулахын зэрэгцээ архивын материалыг дамжуулан зөөж байгаа нь түүний нууцлал, аюулгүй байдал алдагдахад хүргэж байна.

**Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд ажил, үйлчилгээг хөнгөн шуурхай чирэгдэлгүй үзүүлэх зохистой арга хэмжээг авч ажиллахгүй байна**

2.22 УБЕХуулийн 9.1.3-т "улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандартыг мөрдүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж стандартыг баталж гаргасан боловч мөрдөлт хангалтгүй байна.

2.23 ҮХЭХ-ийн бүртгэлийн үйл ажиллагааг 2012 оны 5 дугаар сарын 8-ны өдөр аудитын багаас ажиглахад үйлчлүүлэгчээс хүлээн авсан материалыг "Триада" програмд оруулахад тус программ нь удаан ажиллаж, заримдаа гацаж байсан ба нэг үйлчлүүлэгчид дунджаар 20 минут зарцуулж, үйлчлүүлэгчдийн хувьд нэлээд бухимдалтай, ажилтнуудын хувьд ачаалалтай байлаа.

2.24 Үйлчилгээний стандартыг мөрдөж, үйлчлүүлэгчдэд туслах, зөвлөх байдал хангалтгүй, ажилдаа түүртсэн, үл тоомсорлосон байдал ихэнх ажилтнуудын хувьд ажиглагдсан болно.

2.25 Үйлчилгээний төрөл тус бүрээр цонхыг байрлуулж, үйлчилгээний талаарх мэдээллийг хүлээн авах танхимийн үүдэнд самбарт байрлуулсан хэдий ч үйлчлүүлэгчид заавал үйлчилгээний ажилтнуудаас лавлах явдал түгээмэл байсан.

2.26 Иймд бүртгэлийн үйл ажиллагааны төрөл тус бүрээр иргэдэд зөвлөгөө, тусалцаа үзүүлэх ажилтнуудыг тусад нь бэлтгэж ажиллуулах, үйлчилгээний шат дарааллын дагуу танхимын зохион байгуулалтыг шинэчлэх нь бүртгэлийн үйлчилгээг хөнгөвчлөх, цаг хэмнэхэд чухал үүрэгтэй нь харагдсан.

**УБЕГ-аас ирүүлж байгаа мэдээлэл хангалтгүйгээс татвар ногдуулалт бүрэн хэрэгжихгүй байна**

2.27 Татварын алба ҮХЭХ-ийн мэдээллийг УБЕГ-аас авч ашиглах зорилгоор 3 сайдын хамтарсан тушаал гаргуулж, мэдээллийг 2010 оноос авч, ашиглаж эхэлсэн ч энэхүү мэдээлэлд үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл мэдээлэл бүрэн ороогүй, орон нутгийн мэдээллийн баазын бүрдэлт дутуу байна.

2.28 Татварын албанд мөрдөгдөж байгаа "Татвар төлөгчийг бүртгэх журам"-ын дагуу тухайн үл хөдлөх эд хөрөнгө аль аймаг, сум, дүүргийн нутаг дэвсгэрт байрлаж байна гэдгээс хамаарч аймаг, сум, дүүргийнхээ татварын албанд албан татвар төлөгчөөр бүртгүүлэн, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараа төлөх ёстой.

2.29 Энэ дагуу тухайн сум, дүүрэг, хороо хариуцсан татварын байцаагчид өөрийн нутаг дэвсгэрт оршин буй үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг зурагжуулсан болон дэлгэрэнгүй хэлбэрээр хөтлөн, албан татварын ногдуулалтыг хийн ажиллаж байна.

2.30 ТЕГ "Нийслэлд үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэх журам"-ын төслийг боловсруулан НИТХТ-ийн 2011 оны 121 дүгээр тогтоолоор батлуулж, уг журмыг хэрэгжүүлэх тухай ТЕГ-ын 2011 оны 8 дугаар сарын 10-ны 436, 2011 оны 9 дүгээр сарын 8-ны 518 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллажээ.

2.31 ТЕГ улсын бүртгэлийн мэдээллийн сангаас 2009-2011 онд шинээр бүртгэгдсэн ААНБ, иргэний үл хөдлөх эд хөрөнгийн мэдээллийг цахим хэлбэрээр авсан боловч улсын бүртгэлд бүртгэгдсэн ААНБ, иргэн, тэдгээрийн өмчлөлд байгаа татвар ногдох

эд хөрөнгийг хуульд заасны дагуу татвар төлөгчийн бүртгэлд бүрэн хамруулах, татварын ногдуулалтыг үнэн зөв тогтооход ашиглаагүй, энэ талаар тодорхой ажил зохион байгуулаагүй, бүртгэлийн газраас ирүүлсэн мэдээллийн санд ач холбогдол өгч татварын баазыг нэмэгдүүлэхэд санаачлага гаргаж ажиллаагүй байна.

2.32 ТЕГ-ын мэдээлэл, технологийн газрын бүртгэлийн мэдээллийн санд 2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 9784 үл хөдлөх эд хөрөнгө байгааг УБЕГ-ын Мэдээлэл, технологийн газрын бүртгэлийн мэдээллийн санд шинээр /2009-2011 онд/ бүртгэгдсэн татвар ногдох 6902 үл хөдлөх эд хөрөнгөтэй харьцуулан шалгахад 1473 буюу 310.0 тэрбум төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийг дүүргийн татварын хэлтсийн /ТЕГ-ын мэдээллийн санд/ бүртгэлийн мэдээллийн санд бүртгээгүй байв.

2.33 Мөн 2001-2008 онд 1019 буюу 228.5 тэрбум төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэл мэдээллийн санд бүртгээгүй явж иржээ.

2.34 Энэ нь Тэргүүн шадар сайд, Сангийн сайдын 2010 оны 1 дүгээр сарын 19-ний 04/07 дугаар тушаалаар баталсан журмын 4.2. *“улсын бүртгэлд бүртгээгдсэн хувь хүн, хуулийн этгээд, тэдгээрийн өмчлөлд байгаа татвар ногдох эд хөрөнгийг хуульд заасны дагуу татвар төлөгчийн бүртгэлд бүрэн хамруулах”*, УТЕГ-ын /хуучин нэрээр/ даргын 2009 оны 11 дүгээр сарын 24-ний 527 дугаар тушаалаар баталсан Татвар төлөгчийг бүртгэх журмын 8.3. *“Татварын алба нь бүртгэх байгууллага болон татвар төлөгчөөс ирүүлсэн мэдээллийг үндэслэн татвар төлөгчийн мэдээллийн бааз, хувийн хэрэгт нэмэлт, өөрчлөлт оруулна”* гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

**ҮХЭХАТТухай хуулийн дагуу мөрдөх дүрэм журам гараагүй, эрх зүйн зохицуулалт бүрдээгүй байна**

2.35 ТЕГ-аас 2001 онд “Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хуулийг хэрэгжүүлэх аргачлал”-ыг баталсан боловч ХЗДХЯ 2009 онд хүчингүй болгосон байна.

2.36 Хуульд тухайлан нарийвчлан заагаагүй боловч зайлшгүй шаардлагатай зохицуулалтыг энэхүү аргачлалын хүрээнд хэрэгжүүлж байсан бөгөөд аргачлалыг хүчингүй болгосноор албан татвар төлөгчийг бүртгэх, албан татвар ногдуулах зэрэг зарим ажлыг татварын албанаас хэрэгжүүлэхэд хүндрэл бий болжээ.

2.37 Тухайлбал өмнө мөрдөгдөж байсан аргачлалын хүрээнд үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдээгүй, даатгалын байгууллагад даатгуулаагүй тохиолдолд хөрөнгийн үнэлгээний байгууллагын тодорхойлсон үнийн дүнгээр, хэрэв ингэж тодорхойлоогүй бол орон нутгийн тухайн төрлийн үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн дундаж үнээр татварын алба тодорхойлоод албан татварын ногдуулалт хийн, татварыг хурааж авах ажил зохих зохицуулалтгүй болсон байна.

2.38 Татварын хуулийн хэрэгжилтийг ханган, татвар хураах ажлыг зүй зохистой явуулах нэг нөхцөл нь татварын бүртгэл юм.

2.39 ТЕГ нь ҮХЭХАТТухай хуулийн дагуу УБЕГ-т бүртгэгдсэн үнэлгээгээр бус балансын үнэлгээгээр бүртгэснээр үл хөдлөх эд хөрөнгийг зөрүүтэй үнэлэх нөхцөл бүрджээ. Тухайлбал;

29 ААНБ-ын УБЕГ-ын бүртгэлийн санд бүртгээгдсэн үнэлгээ нь 38.4 тэрбум төгрөг, ТЕГ-ын бүртгэлийн санд бүртгээгдсэн үнэлгээ нь 27.9 тэрбум төгрөг буюу үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ нь 10.5 тэрбум төгрөгөөр дутуу бүртгээгдсэн байна.

2.40 ТЕГ УБЕГ-аас зохих мэдээллийг шаардаж авдаггүй, авсныгаа ашиглахгүй байгаа нь төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хөрөнгийн бүртгэл, татварын ногдуулалт, хураалт, төсвийн орлогын бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

2.41 Хувь хүн, хуулийн этгээдийн татвар ногдох үл хөдлөх эд хөрөнгийг татварын бүртгэлд бүрэн хамруулах, бүртгэлийн мэдээллийг тогтмол хугацаанд харилцан солилцож, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг тухай бүрд нь хийсэн эсэхэд тавих хяналт хангалтгүй байгаа нь Татварын ерөнхий хуулийн 22.1.2 “*татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих*” чиг үүргээ ТЕГ бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

**ЭХЭУБГ, НГА үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс 7895 иргэний ҮХЭХ-ийг татварын бүртгэл, мэдээллийн санд бүртгээгүй байна**

2.42 ЭХЭУБГ нь Газрын харилцаа геодези зураг зүйн газар, ҮТЕГ-ын дарга нарын 2005 оны 2 дугаар сарын 22-ны 30/33 дугаар тушаалаар баталсан “*Газрын албан татвар, төлбөрийн мэдээ, тайлан солилцох журам*”-ын 1.4 “*Газар өмчлөх эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөр газрын албан татвар төлж эхлэх хугацааг тооцно.*”, 2.1 “*Эрхийн улсын бүртгэлийн алба, эрхийн улсын бүртгэгч нь тухайн улиралд шинээр бүртгээгдсэн газар өмчлөгч болон газар өмчлөх эрхийн өөрчлөлтийн мэдээг аймаг, нийслэлийн газрын албанд улирал бүрийн сүүлчийн сарын 25-наас 30-ны хооронд гаргаж өгнө*”, 2.3 “*Аймаг, нийслэлийн газрын албад нь тухайн улиралд шинээр бүртгээгдсэн газар өмчлөгч болон газар өмчлөх эрх өөрчлөгдсөн талаарх ЭХЭУБГ-аас ирүүлсэн мэдээг үндэслэн газрын албан татварын ногдуулалтын улирлын мэдээг маягт ГТМ-2 заасны дагуу нэгтгэн гаргаж улирал бүрийн дараа сарын 20-ны дотор холбогдох аймаг, нийслэлийн татварын албадад хүргүүлнэ.*” гэсэн заалтыг ЭХЭУБГ, НГА хэрэгжүүлээгүй байна.

2.43 Тухайлбал, УБЕГ нь НГА-д мэдээллийг огт хүргүүлээгүй, НГА 2009, 2010, 2011 оны мэдээллийг 2011 оны 11 дүгээр сарын 29-нд цахим хэлбэрээр Нийслэлийн татварын газарт хүргүүлжээ.

2.44 Дээрх журмын заалтууд хэрэгжээгүйгээс ЭХЭУБХ 2011 онд газар өмчлөх эрхийг баталгаажуулсан 11520 иргэнээс 7895 иргэний газрыг татварын бүртгэл мэдээллийн санд бүртгээгүй байна.

2.45 ТЕГ-ын бүртгэл мэдээллийн санд бүртгээгүй 538.5 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 2492 ААНБ, иргэний үл хөдлөх хөрөнгийг мэдээллийн санд бүртгэх шаардлагатай байна.

**Бүртгэлгүй, үнэлгээний зөрүүтэй үл хөдлөх эд хөрөнгө, иргэдийн өмчилсэн газарт 4260.8 сая төгрөгийн албан татварын ногдуулалт хийгээгүй байна**

2.46 2011 оны жилийн эцсийн байдлаар нийт 9784 үл хөдлөх эд хөрөнгөд 12917.5 сая төгрөгийн албан татвар ногдуулжээ.

2.47 УБЕГ-ын бүртгэл мэдээллийн санд 2001-2011 онуудад шинээр бүртгэгдсэн ААНБ, иргэний 9 дүүрэгт байршилтай үл хөдлөх эд хөрөнгийн тоо, үнэлгээг дүүргүүдийн уг татварыг хариуцсан байцаагчтай хамт ТЕГ-ын үл хөдлөх эд хөрөнгийн мэдээллийн санд байгаа бүртгэлтэй тулгахад 187.8 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 1303 ААНБ, 122.2 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 1189 иргэний нийт 538.5 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 2492 үл хөдлөх эд хөрөнгө бүртгэлгүй байв.

2.48 2009-2011 оны Татварын мэдээллийн санд бүртгэлгүй буюу үнэлгээний зөрүүтэй 1473 ААНБ-ын үл хөдлөх хөрөнгөд 2904.8 сая төгрөгийн, иргэний үл хөдлөх эд хөрөнгөд 921.8 сая төгрөгийн, нийт 3826.6 сая төгрөгийн /ЭХЭУБГ-т бүртгүүлсэн өдрөөс хойшхи хугацаанд/ албан татварын ногдуулалт хийгээгүй байна.

2.49 2001-2008 оны Татварын мэдээллийн санд бүртгэлгүй 55 аж ахуйн нэгж, байгууллагын үл хөдлөх хөрөнгөд 415.0 сая төгрөгийн албан татварын ногдуулалт хийгдээгүй байна.

2.50 2011 онд нийт 11520 иргэний өмчилсөн газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас 7895 иргэнд 19.2 сая төгрөгийн албан татварыг газрын албадаас ногдуулаагүй байна.

2.51 Аудитын явцад татварыг нөхөн төлүүлэхээр 9 дүүргийн татварын хэлтэст нийт 4.2 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос ЧД, СХД, БГД, БНД, ХУД-ийн татварын хэлтсүүд нийт 298.0 сая төгрөгийг нийслэл, дүүргийн төсөвт оруулаад байна.

2.52 Дүүргүүдийн нутаг дэвсгэр дээр байрлах зарим ААНБ, иргэдийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөлтийн байдалтай газар дээр нь очиж танилцлаа. Үүнд:

- БГД-ийн нутаг дэвсгэрт байрлах Максмолл, Максложинг ХХК нь 2011 оны 3 дугаар сард ЭХЭУБХ-т үл хөдлөх эд хөрөнгөө бүртгүүлж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байна. Гэтэл БГД-ийн татварын хэлтэс өнөөг хүртэл уг үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэлд аваагүй албан татвар ногдуулаагүй байсанд 27.8 сая төгрөгийн татварын ногдол хийж төсөвт төвлөрүүлэв.
- СБД-ийн нутаг дэвсгэрт байрлах Баянгол зочид буудал ХХК-ийн үл хөдлөх эд хөрөнгөд бүртгэгдсэн үнэлгээ нь 6.8 тэрбум, татварын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн үнэлгээ нь 3.2 тэрбум байв. Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний зөрүү 3.6 тэрбум төгрөгийн үнэлгээнд 21.8 сая төгрөгийн албан татвар ногдууллаа.
- Чингис эко тур, Винтрак, Ийсткэстиль, Бишрэлт трейд, Жаст групп, Номин төв трейд, Автобус 3, Сирень зэрэг ААНБ-уудаар явж үзэхэд нийт 512.0 сая төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын дутуу төлөлттэй байсанд албан шаардлага хүргүүлэв.
- Шинээр баригдсан зарим томоохон объектуудыг өмчлөгч болсон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэд татвараа төлөөгүй, татварын албад татварыг ногдуулж төлүүлэх ажлыг зохион байгуулаагүй байна. Тухайлбал: Бөмбөгөр худалдааны шинэ төв, Victory төв зэргийг дурдаж болно.

**ҮХЭХАТ-ын ногдуулалт, төвлөрүүлэлтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна**

2.53 Татвар төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгийг татварын бүртгэлийн мэдээллийн санд бүрэн хамруулах, ТЕГ, УБЕГ-ууд бүртгэлийн мэдээллийг тогтмол хугацаанд харилцан солилцох журмын хэрэгжилт, авсан мэдээллээ татварын баазад бүртгэж



байгааг хянах, татварт хамрагдалтын байдлыг шалгах, татварт хамрагдаагүй татвар төлөгчийг илрүүлэх, татварын өрийг барагдуулж байгаа эсэхэд тавих дотоод хяналтын тогтолцоо Татварын албадад иж бүрэн үйлчлэхгүй байна.

2.54 ТЕГ Татварын ерөнхий хуулийн 31.2.1-ийн "татвар ногдуулалт, төлөлт, хураалтад хяналт тавьж, шуурхай удирдлагаар хангах" заалтыг хангалтгүй хэрэгжүүлж байна.

2.55 Дүүргүүдийн татварын хэлтэст дүүргийн нутаг дэвсгэрт байршилтай худалдаа үйлчилгээний том, жижиг төвүүд болон захуудад үйл ажиллагаа явуулж байгаа үл хөдлөх эд хөрөнгөтэй иргэдийн судалгаа хангалтгүй, дүүргийн татварын хэлтсийн бүртгэл мэдээллийн системд үл хөдлөх эд хөрөнгийн хаяг, улсын бүртгэлийн дугаар байхгүй байгаа нь Татварын ерөнхий хууль, "Татвар төлөгчийг бүртгэх журам"-ын хэрэгжилт хангалтгүй байгаагаар холбоотой юм.

2.56 Аудитын явцад УБЕГ-ын мэдээллийн сангаас авсан ҮХЭХ-ийн бүртгэлийн мэдээг татварын бүртгэлийн мэдээллийн сантай тулгаж татварын мэдээллийн санд бүртгэлгүй ААНБ, иргэдийн жагсаалтыг дүүргүүдийн татварын хэлтэст хүргүүлснээр дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

- БГД-ийн татварын хэлтэст хугацаатай үүрэг өгснөөр тус дүүргийн хэлтсийн даргын 2012 оны 5 дугаар сарын 18-нд баталсан удирдамжаар "Гранд плаза" цогцолборын 7-15 давхарт үйл ажиллагаа явуулдаг 71 ААН, иргэнээс 21-ийг нь татварын мэдээллийн санд бүртгэж татварт хамруулан 43.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 45 ААН, иргэнд мэдэгдэх хуудас хүргүүлсэн байна.
- БЗД-ийн татварын хэлтэс "Сандэй плаза" худалдааны төвд үйл ажиллагаа явуулдаг 110 ААНБ, иргэдийг татварын бүртгэлийн мэдээллийн санд оруулж, 59.9 сая төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулсан байна.
- ЧД-ийн татварын хэлтэс 45 ААН-ийг шинээр бүртгэж нийт 86.5 сая төгрөгийн албан татвар ногдуулсан, 24 иргэнийг шинээр бүртгэж 28.8 сая төгрөгийн ногдуулалт хийж 70 гаруй иргэн, 41 ААН-д хугацаа зааж мэдэгдэх хуудас хүргүүлсэн байна.
- СХД-ийн татварын хэлтэс 26 ААН-ийг шинээр бүртгэж, 79.7 сая төгрөгийн ногдуулалт хийж төсөвт төвлөрүүлсэн байна.

2.57 2009-2011 оны Татварын мэдээллийн санд бүртгэлгүй буюу үнэлгээний зөрүүтэй 1473 аж ахуйн нэгж, байгууллагын үл хөдлөх хөрөнгөд 2904.8 сая төгрөгийн, иргэний үл хөдлөх эд хөрөнгөд 921.8 сая төгрөгийн, нийт 3826.6 сая төгрөгийн, 2001-2008 оны Татварын мэдээллийн санд бүртгэлгүй 55 аж ахуйн нэгж, байгууллагын үл хөдлөх хөрөнгөд 415.0 сая төгрөгийн, 7895 иргэний 19.2 сая төгрөгийн газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын ногдуулалт хийж төсөвт төвлөрүүлэхээр нийт 4260.8 сая төгрөгийн төлбөрийн акт бичив.

**2011 онд ногдуулсан үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас 2.5 тэрбум төгрөгийг хугацаанд нь бүрэн төвлөрүүлээгүй байна**

2.58 ҮХЭХАТ-ын төлөлт ТЭХууль болон ҮХЭХАТТухай хуулийн 8-д<sup>2</sup> заасан заалтаар зохицуулагдаж, төлөлт хураалтын ажиллагаа явагддаг.

<sup>2</sup> 8.1-д "Татвар төлөгч нь үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар байгаа үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээгээр тооцно" ... 2-т "Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч хуулийн этгээд нь үл хөдлөх эд хөрөнгийн жилийн албан татварыг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор тэнцүү хэмжээгээр тооцож төлнө", ... 3-т "Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч Монгол Улсын иргэн, гадаадын иргэн,

2.59 2011 онд ҮХЭХАТ-ын төлөвлөгөө 9106.7 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 10371.5 сая төгрөгийг хурааж, гүйцэтгэл 1264.8 сая төгрөг буюу 13.9 хувиар тус тус давуулан биелжээ. Өмнөх онтой харьцуулахад ҮХЭХАТ 1718.3 сая төгрөг буюу 19.9 хувиар нэмэгджээ. /Хүснэгт №3-ыг үзнэ үү/

Хүснэгт №3

Нийслэл, дүүргийн татварын албадын Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын 2011 оны төлөвлөгөө, хураалтын судалгаа

(мян.төг)

Д.д	Дүүрэг	Татвар төлөгчийн тоо	ҮХЭХ-ийн тоо	Төлөвлөгөө	Хураалт /гүйцэтгэл/	Хувь	Давалт /+/, Тасралт /-/
1	БГД	1 283	1 510	1 879 561.4	2 133 902.5	113.5	254 341.1
2	БЗД	1 351	1 453	1 294 265.6	1 454 563.6	112.4	160 298.0
3	ЧД	1 024	1 186	988 757.4	1 145 912.8	115.9	157 155.4
4	СХД	737	963	721 515.0	768 893.5	106.6	47 378.5
5	СБД	1 180	1 511	2 010 870.8	2 440 749.7	121.4	429 878.9
6	ХУД	1 766	2 012	1 952 882.3	2 042 658.4	104.6	89 776.1
7	НД	583	752	125 087.2	143 968.8	115.1	18 881.6
8	БНД	335	397	129 833.8	224 623.5	173.0	94 789.7
9	БХД			3 926.1	5 348.7	136.2	1 422.6
10	НТГазар			-	10 896.5		10 896.5
	Дүн	8 259	9 784	9 106 699.8	10 371 518.0	113.9	1 264 818.2

2.60 ҮХЭХ-ийн албан татварын төлөвлөгөө нь хэдийгээр 13.9 хувиар давж биелсэн боловч нөгөө талаас татвар төлөгч зарим ААНБ, иргэдийн 2546.0 сая төгрөгийн албан татварыг хуулийн хугацаанд нь бүрэн хураагаагүй нь ажлын зохион байгуулалтыг оновчтой болгох, нөөц бололцоогоо бүрэн дайчлах, татварын орлогын төлөвлөлт, түүний үндэслэлийг бодитой болгох шаардлагатайг харуулж байна.

2.61 Мөн ҮХЭХ-ийн ногдуулсан албан татварыг хуульд заасан хугацаанд бүрэн төвлөрүүлэх, дутуу төлөлтөд хуулийн дагуу хоногийн алданги, хүү тооцож, татвар төлөлтийг үнэн зөв бүртгэх, хэлтэс тасгуудын ажлын уялдаа холбоо, татвар төлөлт, хураалтын ажилд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

### Бүлэг 3. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг бүрэн хурааж чадахгүй байна

#### Оршил

3.1 ТЭХуулийн 7.4 дүгээр зүйлд “Улсын Их Хурал, Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хувь хэмжээг нь тогтоож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, эсхүл тухайн нутаг дэвсгэрт үйлчлэх дараахь татвар орон нутгийн татварт хамаарах” ба 7.4.3-т “үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар”, 7.4.6-д “автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар байна” гэж тодорхойлсон байна.

3.2 ТЭХуулийн 8.5-д “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 7.4.3, 7.4.6-д заасан хувь, хэмжээг Улсын Их Хурлаас баталсан хязгаарт багтаан тогтооно” гэж заажээ.



#### АТБӨЯХАТ-ыг хураах байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна

3.3 ТЭХууль, АТБӨЯХАТТ хуулиар ТЕГ, АТГ-ын хэрэгжүүлэх үүрэг, зорилтыг тодорхойлжээ.

3.4 АТБӨЯХАТТухай хуулийн 8.1-д "Замын хөдөлгөөн зохицуулах байгууллага нь автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшигчийн тухайн нутаг дэвсгэрийн татварын албатай албан татварын тооцоо хийсэн тухай тодорхойлолтыг үндэслэн шилжилт хөдөлгөөнийг бүртгэнэ. Замын хөдөлгөөн зохицуулах байгууллага нь авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний мэдээг тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд улирал тутам гаргаж өгнө" гэж заасан байна.

3.5 АТТХуульд 2008 онд орсон өөрчлөлт, МУ-ын ЗГ-ын 2008 оны 64 дүгээр тогтоолоор ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг АТГ-ыг байгуулж, 2009 оны 8 дугаар сарын 18-ны “АТТХуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 251 дүгээр тогтоолоор АТБӨЯХ-ийг бүртгэх, хөтлөх, улсын дугаар олгох ажлыг ЗЦГ-аас АТГ-т шилжүүлж эрх, үүргийг нь тодорхой зааглаж өгчээ.

3.6 ХЗДХС, ЗТБХБС-ын 2010 оны 26/43 дугаар тушаалаар баталсан харилцан мэдээлэл солилцох журмын дагуу АТГ, ТЕГ-ын хооронд байгуулсан 2010 оны 43 дугаартай “Хамтран ажиллах” гэрээний 2.1.3-т “Автотээврийн газар нь АТХБӨЯХ-ийн бүртгэлийн асуудлаар Татварын ерөнхий газартай байнгын сүлжээгээр холбогдож, бүртгэл мэдээллийн нэгдсэн сантай болох”, 2.1.4-т “Хоёр тал байнгын сүлжээгээр холбогдоогүй нөхцөлд шинээр улсын дугаар авсан, шилжилт хөдөлгөөн хийгдсэн, улсын бүртгэлээс хасагдсан мэдээллийг Татварын ерөнхий газарт сар бүр

файл хэлбэрээр дараа сарын 5-ны өдрийн дотор гаргаж өгч байх” гэж заасан боловч АТГ-аас ТЕГ-т 2011 оны 12 дугаар сар, 2012 оны 4 дүгээр сард цахимаар тус тус хүргүүлсэн байна.

3.7 АТГ автотээврийн хэрэгсэлд улсын дугаар олгох, бүртгэл хөтлөх, шилжилт хөдөлгөөнийг хийх, бүртгэлээс хасах, автотээврийн хэрэгслийн лавлагаа мэдээлэл өгөх, АТБӨЯХ-ийн бүртгэл, мэдээллийн санг шинэчлэн цахим санд шилжүүлэн баяжилт хийх ажлуудыг зохион байгуулж байгаа ч татварын албадыг хуулийн дагуу АТБӨЯХ-ийн улсын бүртгэлийн мэдээллээр хангахгүй, АТБӨЯХ-ийн албан татварын хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь заалтуудыг хэрэгжүүлэхгүй байна.

3.8 “Агаарын бохирдлын төлбөрийн тухай” хуулийн 9.3-т “Төлбөр төлөгч нь автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдох жилийн төлбөрийг жилд нэг удаа тухайн жилийн 6 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө харьяалах татварын албанд төлнө” гэж заасны дагуу АТБӨЯХАТ-ыг агаарын бохирдлын төлбөртэй хамт хураах ажлыг зохион байгуулж байна.

3.9 Тухайн тээврийн хэрэгсэл нь техникийн хяналтын үзлэг, оношлогоонд хамрагдаж, агаарын бохирдлын төлбөрийн ангилалаа тогтоолгосны үндсэн дээр агаарын бохирдлын төлбөрөө төлөх боломжтой болох юм.

3.10 Гэвч ТХОХЗА 6 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө бүх тээврийн хэрэгслийг техникийн үзлэг оношлогоонд хамруулах техникийн хүчин чадал нь хүрэлцдэггүй байна.

3.11 АТБӨЯХАТТухай хуулийн дагуу ачааны автомашин болон чиргүүлийн албан татварыг даацаас нь хамааруулан тогтоохоор заасан боловч Авто тээврийн газарт ачааны автомашин болон чиргүүлийн даацын мэдээллийг бүрэн бүртгээгүйгээс татвар хураах ажилд хүндрэл учирч байна.

3.12 Татварын албанаас АТБӨЯХАТ, агаарын бохирдлын төлбөрийг төлсөн нөхцөлд гурвалжин наалт тэмдгийг олгож байгаа боловч энэ наалт тэмдгээр албан татвар төлсөн эсэхэд Замын цагдаагийн газраас бүрэн хяналт тавьж чадахгүй байна.

3.13 Авто тээврийн газраас тээврийн хэрэгслийг шилжүүлэх, улсын дугаар солих, тээврийн үйлчилгээ хийх зөвшөөрөл олгох, тээврийн хэрэгслийн оношлогоонд хамрагдахаас өмнө АТБӨЯХ-ийн албан татварыг төлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

3.14 ТЕГ АТБӨЯХ-ийн бүртгэл, татвар ногдуулалт, төлөлтийг татварын албаны "Autotax" программ, АТГ "VRS" программ ашиглан бүртгэлийг хөтөлж байна.

3.15 Одоогоор ТЕГ, АТГ, ТХОХЗА тус тусдаа бүртгэлийн бааз үүсгэж, тээврийн хэрэгсэл бүртгэж байгаа бөгөөд тээврийн хэрэгслийн бүртгэлийн ажлыг хуульд заасны дагуу зөвхөн АТГ бүртгэх, энэхүү бүртгэлийг үндэслэн Татварын алба тээврийн хэрэгслийн татварыг хураах нөхцөл бүрдээгүй байна.

**ААНБ, иргэдэд үзүүлэх үйлчилгээ ихээхэн хүндрэлтэй, цаг хугацаа их шаардаж байна**

3.16 ТЕГ-аас татвар хураах үйл ажиллагааг татвар төлөгчдөд чирэгдэлгүй хөнгөн шуурхай хүргэж ажиллах зорилгоор Улаанбаатар хотод тээврийн хэрэгслийн үзлэг, оношлогоо явуулж буй байруудад татварын байцаагч гарган ажиллуулж, тээврийн хэрэгсэлтэй холбоотой үйлчилгээг нэг дороос шуурхай үзүүлэх нөхцөл боломжийг ханган ажиллаж байна.

3.17 Дүүргүүдийн татварын хэлтсийн “Нэг цэгийн үйлчилгээний танхим”-аар болон Улаанбаатар хотын төвийн дүүргүүдэд “Явуулын албан татвар төлбөр хураах” цэгийг гарган ажиллуулж байна.

3.18 Гэвч АТГ-аас хэрэгжүүлдэг тээврийн хэрэгслийн бүртгэл, ТХОХЗА-аас хэрэгжүүлж буй оношлогооны ажил иргэдэд хүндрэл чирэгдэл үүсгэж байна. Тухайлбал, "Да хүрээ зах", "Хөсөг трэйд" ХХК-ууд дээр байрлах цэгийн үйлчлүүлэгчдээс авсан санал асуулгаар:

*Дээрх байгууллагын үзүүлж буй зөвхөн нэг үйлчилгээг авахын тулд дунджаар 5 цаг зарцуулж байна.*

- Санал асуулгад оролцогчдын 68.4 хувь нь үйлчилгээний ажилтны зан, харьцаа муу, ажлын цагтаа ажлын байран дээрээ байдаггүй, хүнд суртал гаргадаг, үзүүлж буй үйлчилгээний чанар муу, тухайн үйлчилгээг авахын тулд бүрдүүлэх материалын талаар зөвлөгөө өгөхдөө тааруу гэж үзсэн байхад,
- 34.2 хувь үйлчилгээний цэг болон төлбөр тушаах банкин дээр дараалал ихтэй,
- 28.9 хувь үйлчилгээний цэгийн байршил оновчгүй, тоо цөөн,
- 18.4 хувь үйлчилгээний цэгүүдийн тохижилт, багтаамж муу, үйлчлүүлэгчдэд таниулах зорилгоор байрлуулсан самбарын мэдээлэл ойлгомж муу, цэгцгүй гэжээ.

3.19 Цаашид дээрх байдлыг арилгахын тулд үйлчилгээний цэгийг олшруулах, онлайн үйлчилгээг нэвтрүүлэх, үйлчилгээг аль болох түргэн шуурхай болгож өгөхийг хүссэн байна.

**АТГ АТБӨЯХ-ийн улсын бүртгэлийг ангиллын дагуу бүрэн гүйцэд хөтлөөгүй байна**

3.20 АТБӨЯХ-ийн цахим бүртгэл мэдээллийн санд 2011 оны жилийн эцсийн байдлаар нийслэлийн хэмжээнд 292352 тээврийн хэрэгслийг бүртгэсэн байна. /Хүснэгт №4-ийг үзнэ үү/

Хүснэгт №4

Нийслэлд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл

№	Дүүрэг	Тээврийн хэрэгслийн тоо	Авто тээврийн болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн төрөл						
			суудал	ачаа	автобус	мотоцикл	тусгай	трактор	чиргүүл
1	БГД	55 643	41 670	5 656	1 185	570	2 524	1 286	2 752
2	БЗД	66 091	50 546	8 853	1 048	783	2 162	651	2 048
3	БНД	3 707	2 631	815	39	125	40	9	48
4	БХД	609	464	105	15	2	10	6	7
5	НАА	3 922	2 408	1 280	38	18	76	40	62
6	СБД	43 573	32 827	3 493	1 024	291	2 392	867	2 679
7	СХД	53 789	39 778	8 477	1 561	411	1 565	427	1 570
8	ХУД	28 272	20 842	3 161	619	314	1 311	334	1 691
9	ЧД	36 746	28 543	4 193	770	419	1 238	538	1 045
	Дүн	292 352	219 709	36 033	6 299	2 933	11 318	4 158	11 902

3.21 АТГ-ын нийслэлд бүртгэлтэй 292352 авто тээврийн хэрэгслийн тээврийн мэдээллийг ангилан шалгахад суудлын автомашины хөдөлгүүрийн багтаамж /см<sup>3</sup>/-ийг 1 гэсэн тоогоор тэмдэглэсэн, ачааны автомашин болон чиргүүлийн даац, трактор өөрөө явагч хэрэгсэл, бага оврын трактор, тусгай зориулалтын автомашины хөдөлгүүрийн багтаамж зэргийг бүртгээгүй нийт 80.0 гаруй мянган тээврийн хэрэгсэл байна.

3.22 АТГ тээврийн хэрэгслийн бүртгэлийг зохих ёсоор бүртгээгүй нь ЗТБХБС-ын 2010 оны 19 дүгээр тушаалаар баталсан “Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох” журмыг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

**Татварын албад АТБӨЯХ-ийн 84466 албан татвар төлөгчийг үнэн зөв бүртгээгүй байна**

3.23 2011 оны 12 сарын 31-ний байдлаар нийслэлд бүртгэлтэй 292352 авто тээврийн хэрэгсэл, дүүргүүдийн татварын баазад бүртгэлтэй 207886 тээврийн хэрэгслийн улсын дугаараар дүүргүүдийн татварын “АУТОТАХ” болон “Normal-auto” програмын бүртгэлд байгаа эсэхийг шалгахад 84466 тээврийн хэрэгсэл дүүргүүдийн татварын албадад бүртгэлгүй байна.

3.24 ТЕГ нь АТГ-аас тээврийн хэрэгслийн бүртгэлийг 2 удаа цахимаар авсан боловч дүүргийн татварын албадын мэдээллийн баазыг баяжуулаагүй, харилцан мэдээлэл дамжуулснаа хүлээлцээгүйгээс БЗД, БГД, СХД, БНД, НД, СБД-ийн татварын албад ТЕГ-аас бүртгэл мэдээллийг файлаар аваагүй гэж тайлбар ирүүлсэн байна.

3.25 Татварын албадын ашиглаж буй “АУТОТАХ” болон “Normal-auto” программын мэдээллийн давхардлыг хянахад нэг дүүрэгт бүртгэлтэй байгаа тээврийн хэрэгслийг нөгөө дүүрэгт давхардуулан 2-4 удаа бүртгэжээ. /Хүснэгт №5/

Хүснэгт №5

Тээврийн хэрэгслийн бүртгэлийн давхардал

Үзүүлэлт	Дүүрэг									Дүн
	БГД	БЗД	БНД	БХД	НД	СБД	СХД	ХУД	ЧД	
НТГ-аас ирүүлсэн ТЕГ-т бүртгэлтэй ТХ-ийн тоо	43 225	58 728	1 977	308	3 332	38 216	38 789	23 377	27 780	235 642
Дүүргийн ТА-дад бүртгэлтэй ТХ-ийн тоо	35 057	53 299	1 973	306	3 108	35 278	34 678	20 405	23 782	207 886
Нэг улсын дугаар 2-4 удаа давхцсан тоо	8 168	5 429	4	2	224	2 938	4 111	2 972	3 908	27 756

3.26 Түүнчлэн татвар төлөгчийг мэдээллийн санд оруулахдаа татвар төлөгчийн нэр, татвар төлөгчийн дугаар, татварын гэрчилгээ, регистрийн дугаарыг буруу оруулж байна. Тухайлбал:

- Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн АТБӨЯХ-ийн бүртгэл мэдээллийн санд тээврийн хэрэгслийг эзэмшигч нь тодорхойгүй байхад /татвар төлөгчийн нэрийг/ СБД-Т Хэлтэс гэсэн нэрээр, татвар төлөгчийн регистрийн дугаарыг /татвар төлөгчийн дугаар/ тус дүүргийн татварын албаны улсын бүртгэлийн гэрчилгээний дугаараар бүртгэсэн байна.

- Чингэлтэй дүүргийн татварын бүртгэл мэдээллийн санд тээврийн хэрэгслийн эзэмшигчийн нэрийг орлуулан УБХБС гэсэн нэрээр, татвар төлөгчийн регистрийн дугаарыг ЖЮ88053060 регистрээр, татварын гэрчилгээний дугаарыг 0000000 тэмдэглэгээгээр тус тус давхардуулан тэмдэглэжээ.

3.27 Дээрхээс харахад ТЕГ-ын даргын 2009 оны 527 дугаар тушаалаар баталсан “Татвар төлөгчийг бүртгэх журмын 2.1-д ”... татвар төлөгчийн бүртгэлийн дугаар нь татвар төлөгчид зөвхөн нэг удаа олгогдох байнгын дугаар байна”, 2.3-т “Монгол Улсын иргэний хувьд тэдгээрийн иргэний үнэмлэхэд бичигдсэн регистрийн дугаар нь Татвар төлөгчийн бүртгэлийн дугаар байна” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

3.28 Дүүргийн татварын албад 2564 тээврийн хэрэгслийг АТГ-ын улсын бүртгэлээс зөвшөөрөлгүйгээр мэдээллийн сангаасаа хассан нь АТБӨЯХАТ-ын хуулийн 6.2-ын “Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл ашиглалтаас хасагдсан тохиолдолд улсын бүртгэлээс хассан тухай албан ёсны баримт бичгийг үндэслэн ...” гэсэн заалтыг зөрчжээ.

**АТБӨЯХ-ийг зөрүүтэй бүртгэснээс 88613 тээврийн хэрэгсэлд 2900.7 сая төгрөгийн татвар дутуу ногдуулсан байна**

3.29 Дүүргийн татварын албадаас 2010 онд 163953 тээврийн хэрэгсэлд 5878.3 сая төгрөгийн, 2011 онд 208543 тээврийн хэрэгсэлд 12190.3 сая төгрөгийн албан татварыг ногдуулжээ.

3.30 2011 оны татвар ногдуулалтаас 8938 тээврийн хэрэгслийн татварын ногдуулалтыг түүвэрлэн шалгахад 4147 тээврийн хэрэгсэлд 195.3 сая төгрөгийн албан татвар ногдуулаагүй байна. /Хүснэгт №6/

Хүснэгт №6

Албан татвар ногдуулалт дутуу тээврийн хэрэгсэл

№	Үзүүлэлт	Дүүрэг									Нийт
		БГД	БЗД	БНД	БХД	НД	СБД	СХД	ХУД	ЧД	
1	2010-2011 онуудад ногдол хийгээгүй тээврийн хэрэгслийн тоо	696	364	1	-	4	476	1 667	120	819	4 147
2	2010-2011 оны тарифаар ногдуулалтыг тооцсон дүн	46.3	13.1	0.06	-	0.19	21.2	75.2	6.0	33.3	195.3

3.31 АТГ-ын бүртгэлээс дүүргүүдийн татварын албадад бүртгээгүй байгаа 84466 тээврийн хэрэгсэлд 2705.4 сая төгрөгийн албан татварыг ногдуулаагүй байна.

3.32 Дүүргийн татварын албадад бүртгэлгүй 84466, дутуу ногдуулсан 4147, нийт 88613 тээврийн хэрэгсэлд албан татварыг нөхөн ногдуулж орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**3972.9 сая төгрөгийн албан татварыг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна**

3.33 Дүүргүүдийн татварын албадад бүртгэлтэй байгаа 207886 тээврийн хэрэгслээс 27087 тээврийн хэрэгслийг түүвэрлэж татварын дутуу төлөлт байгаа эсэхийг 2012 оны 5 дугаар сарын 20-ны байдлаар шалгахад нийт 17945 тээврийн хэрэгслийн 942.9 сая төгрөгийн албан татварыг холбогдох хуулийн этгээд, хувь хүнээр төлүүлээгүй байна. */Хүснэгт №7/*

*Хүснэгт №7*

Дутуу төлөлттэй тээврийн хэрэгсэл

№	Дүүрэг	Тээврийн хэрэгслийн тоо	Татвар төлөөгүй дүн
1	БГД	6 345	337.5
2	БЗД	6 766	349.1
3	БНД	25	1.1
4	БХД	-	-
5	НД	2	0.07
6	СБД	1 829	103.5
7	СХД	1 515	78.9
8	ХУД	100	3.7
9	ЧД	1 363	69.1
	Дүн	17 945	942.9

3.34 Үлдэх 9142 тээврийн хэрэгслийн 267.1 сая төгрөгийн албан татварыг хурааж авахаас 228.5 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлж, 914 тээврийн хэрэгслийн 38.6 сая төгрөгийн татварыг хөдөө орон нутагт төлсөн нь тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналт муу байгаатай холбоотой байна.




## Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.
- Татвар ногдуулах, хураахад шаардлагатай мэдээллийн нэгдсэн сан бүрэн бүрдээгүй, Улсын бүртгэлийн ерөнхий газар үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой зарим мэдээллийг гаргахад хүндрэл учирч байна.
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын зарим дүүргүүд дэх салбарын мэдээллийн сангийн аюулгүй байдал, хадгалалт, хамгаалалт нууцлал алдагдаж болзошгүй байдал үүссэн байна.
- Тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажлын үр дүн хангалтгүй, мэдээлэл солилцооны цахим технологийн орчин бүрдээгүй байна.
- Татварын ерөнхий газраас татвар төлөгчдийн мэдээллийн баазыг өргөтгөж, мэдээллийн технологийг нэвтрүүлэх, програм хангамжийн ашиглалтыг сайжруулах талаар тодорхой ажлуудыг хийж эхэлсэн ч ажлын үр дүн хангалтгүй, явц удаашралтай байна.
- 2001-2011 онд 2492 эзэмшигчдийн 538.5 тэрбум төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэл мэдээллийн санд бүртгээгүй, 2011 онд татвар төлөгч зарим ААНБ, иргэдийн 2546.0 сая төгрөгийн албан татварыг хуулийн хугацаанд нь бүрэн хурааж төсөвтөө төвлөрүүлээгүй, ААНБ, иргэдийн үл хөдлөх эд хөрөнгө, иргэдийн өмчилсөн газарт 4260.8 сая төгрөгийн албан татварын ногдуулалт хийгдээгүй байна.
- Автотээврийн газар 80.0 гаруй мянган тээврийн хэрэгслийн бүртгэлийг зохих ёсоор бүртгээгүй, бүртгэл зөрүүтэйгээс 2900.7 сая төгрөгийн татвар дутуу ногдуулсан байна.

**Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн санал:**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ОРЛОГЧ Б.БАТБАЯР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

14171 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Цэцэгдэгийн гудамж, Утас: 25-47-97, Факс: (978-11) 35-02-88  
E-mail: contact@registrationmongolia.com,  
http://www.registrationmongolia.com

2012.06.29 № 1/6032  
Танай 2012.06.25-ны № 8/8 -Т

Санал хүргүүлэх тухай

Таны 2012 оны 818 тоот албан бичгээр ирүүлсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Үндэсний аудитын газраас «Үл хөдлөх эд хөрөнгө, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүх төрлийн татвар ногдуулалт, хураалтын бодлого, үр дүн» гэсэн чиглэлээр тус газрын үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлангийн холбогдох хэсгүүдэд дараах тайлбар, саналыг гаргаж байна. Үүнд:

- Тайлангийн 2.7-д «Мэдээллийг тухайн програмд оруулахдаа хүлээн авах танхимаар үйлчлүүлсэн иргэдийн мэдээллийг л зөвхөн оруулж байгаа ба бичиг хэргээр дамжсан мэдээлэл бүрэн ордоггүй байна» гэжээ.
 

Байгууллагын бичиг хэргээр зөвхөн төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэдээс бүртгэл хийлгэхээс бусад асуудлаар тус байгууллагад хандсан албан бичиг, өргөдөл, гомдлыг хүлээн авдаг бөгөөд үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ хийлгэхтэй холбоотой материалыг үйлчилгээний танхимаар хүлээн авч, үйлчилгээ үзүүлдэг.

Иймд бичиг хэргээр ирсэн материалыг бүртгэлийн цахим мэдээллийн санд оруулахгүй байгаа нь үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн сангийн бүрдэлд нөлөөлөхгүй юм.
- Тайлангийн 2.8-д мөн бодит байдлаас зөрүүтэй дүгнэлт хийжээ.
 

2001 оноос цахим мэдээллийн санг бүрдүүлж, ашиглаж эхэлсэн ба ингэхдээ өмнө хийгдсэн бүртгэл буюу 1997 оноос эхлэн хийгдсэн үл хөдлөх эд хөрөнгийн бүх бүртгэлийн мэдээллийг нөхөж оруулсан болно.

Холбогдох хууль тогтоомжийн дагуу татварын байгууллагад хүргүүлж байгаа мэдээнд өмлөгч өөрчлөгдсөн болон шинээр бүртгүүлсэн үл хөдлөх эд хөрөнгийн талаарх мэдээлэл үүнд бүрэн хамрагдаж байгаа болно.
- Харин тайлангийн 2.11-дэх хэсгийн дүгнэлт ойлгомжгүй байна.
 

Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18.2-т «бүртгэлийн гэрчилгээнд ерөнхий болон улсын бүртгэгч, орон нутагт улсын

**ҮАГ-ын тайлбар  
1.1-ийг үзнэ үү**

**ҮАГ-ын тайлбар  
1.2-ыг үзнэ үү**

**ҮАГ-ын тайлбар  
1.3-ыг үзнэ үү**

**ҮАГ-ын тайлбар  
1.4-ийг үзнэ үү**

бүртгэгч гарын үсэг зурж тэмдэг дарна» гэсэн хуулийн заалтыг тус газар мөрдөн ажиллаж, гэрчилгээг ерөнхий болон улсын бүртгэгчийн гарын үсэг, тэмдгээр баталгаажуулж байгаа бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газрын бүтэц өөрчлөгдсөн нь хуулийн дээрх заалтын хэрэгжилтэд ямар нэгэн нөлөө үзүүлээгүй болно.

4. Тайлангийн 2.16-д улсын хэмжээний бүртгэлийн мэдээ, тайланг нэгтгэн гаргах ажлыг хариуцан ажиллах орон тоо, мэргэжилтэн байхгүй талаар дурдсан нь үндэслэлгүй байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн мэдээг улсын хэмжээнд нэгтгэн гаргах ажлыг тус газрын Бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч хариуцан гүйцэтгэдэг бөгөөд мэдээ, тайланг хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна.

**ҮАГ-ын тайлбар  
1.5-ыг үзнэ үү**

5. Мөн тайланд тус газрын бүтцийн өөрчлөлтийг урьдчилан тооцоолж бэлтгэл хангаагүй хийснээс дүүргүүдийн бүртгэлийн архивын үйл ажиллагаа явуулж байгаа байр зориулалтын бус, архивын материалын хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал шаардлага хангахгүй байгаа талаар дурдсаныг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлахдаа тодорхой бодлого, зорилтыг дэвшүүлж, судалгаа, тооцоонд үндэслэсэн бөгөөд бүртгэлийн архивын аюулгүй байдлыг хангах, архивын байрны зай талбай, багтаамжийг тэнцвэржүүлэх, архивын үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор тус газрын Улсын бүртгэлийн төв архивын газрын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын хэлтэст хадгалагдаж байгаа нийслэлийн зарим дүүргийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хувийн хэргийг дүүргийн Бүртгэлийн хэлтэст шилжүүлэн байрлуулах зохион байгуулалтын арга хэмжээг авсан бөгөөд дүүргийн бүртгэлийн архивын үйл ажиллагаа хуульд заасан журмын дагуу хэвийн явагдаж байгаа болно.

**ҮАГ-ын тайлбар  
1.6-г үзнэ үү**

6. Тайлангийн 2.17-д Бүртгэлийн хяналтын нэгжийн хяналт сул байгаа талаар дурдсан байна.

Иргэн, хуулийн этгээдийн мэдүүлгийг хүлээн авсан улсын бүртгэгч Үл хөдлөх эд хөрөнгийн мэдээллийн санд мэдээллийг гэрээний төрлүүдээр оруулдаг бөгөөд дүүрэг хариуцсан улсын бүртгэгч тухайн гэрээний төрлийн мэдүүлэг болон нотлох баримтыг шалгаад тухайн мэдүүлгээр гаргасан нотлох баримт нь бүртгэлийн холбогдох хууль журамд нийцсэн тохиолдолд холбогдох бүртгэлийг хийж, боловсруулах дарааллаар явагддаг.

Улсын бүртгэгчийн алдаатай боловсруулсан мэдээллийг "Техникийн алдаа" гэсэн процессын төрлөөр засвар өөрчлөлтийг хийдэг ба Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн сангийн баяжилтыг мэдүүлэг хүлээн авч байгаа бүртгэгч тухай бүр нь мэдээллийн санд оруулдаг. Мэдээллийн санд ороогүй мэдүүлгээр ямар нэгэн үйлчилгээ үзүүлдэггүй болно.

Тус газар цаашид эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр мэдээллийн санд орж буй мэдээллийг үнэн зөв бодитой эсэх асуудалд онцгой анхаарч ажиллах бөгөөд эд хөрөнгийн бүртгэлд одоогийн ашиглагдаж буй програм нь шинэчлэгдэж боловсронгуй болсон тохиолдолд энэхүү чиглэлийн ажил илүү үр дүнд хүрэх боломжтой юм.

Иймд тус газрын гаргасан дээрх тайлбарыг үндэслэж аудитын тайлангийн төслийн «Дүгнэлт» болон «Зөвлөмж хэсгийг дахин нягталж, өөрчлөлт оруулах саналыг үүгээр хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

ДАРГА



*[Handwritten signature]*  
Я.АМАРСАНАА

**Авто тээврийн газраас ирүүлсэн санал:**




МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**АВТО ТЭЭВРИЙН ГАЗАР**  
 14251 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
 Чингисийн өргөн чөлөө 11, Утас: 7011-2333,  
 Факс: (976-11) 31-23-15, E-mail: transdep@mongol.net

2012.07.02 № 1/1732  
 тантай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г


**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ**

Үндэсний аудитын газраас "Үл хөдлөх эд хөрөнгө, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүх төрлийн татвар, ногдуулалт, хураалтын бодлого, үрд дүнд"-д хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад тайлбарыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 5 хуудастай.

ДАРГА  П.ДЭЛГЭРНАРАН

**ҮАГ-ын тайлбар  
2.1-ыг үзнэ үү**



улсын бүртгэлд бүртгэгдээгүй тээврийн хэрэгслийн тоог гаргахаар нийслэлийн 6 дүүрэгт хяналт шалгалт хийж, нийтдээ 80 орчим авто зогсоолд 4000 орчим суудлын, 474 ачааны, 183 механизм, нийт 4654 тээврийн хэрэгсэл бүртгүүлээгүй байгааг илрүүлж, тэдгээрийг бүртгүүлэх талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хугацаатай албан шаардлага хүргүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавьж байна.

**1.11, 3.11, 3.21.** Засгийн газрын 2009 оны 251 тогтоолын 1<sup>о</sup> –д "Авто тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санг ЗЦГ-с АТГ-т электрон хэлбэрээр болон хувилж шилжүүлэх ажлыг 2009 оны 9-р сард багтаан хийж дуусгах" гэж заасан байна. Тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ЗТБХБЯ-ны сайд, ХЗДХЯ-ны сайдын 2009 оны 244/196 дугаар хамтарсан тушаалаар Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагааг ЗЦГ-аас АТГ-т шилжүүлэн авах хамтарсан ажлын хэсгийг байгуулж ажилласан. Уг ажлын хэсэг 8 удаа хуралдсан хэдий ч тээврийн хэрэгслийн мэдээллийн санг электрон хэлбэрээр шилжүүлэх асуудал шийдвэрлэгдээгүй болно. Авто тээврийн газраас энэ асуудлаар Замын цагдаагийн газарт удаа дараа албан бичиг хүргүүлсэн ч тодорхой үр дүнд хүрээгүй.

Цаасаар хуулбарлан авсан мэдээллүүдийг аль болох бүгдийг цахим хэлбэрт шивж оруулахаар манай ажилтнууд чармайн ажилласан ч өмчлөгч нь тодорхойгүй, арлын дугаар байхгүй, марк модель тодорхойгүй, улсын дугаар давхардсан зэрэг зөрчлийн улмаас АТГ-ын тээврийн хэрэгслийн бүртгэлийн санд мэдээллийг дутуу байдлаар оруулан нэгдсэн сан үүсгэсэн.

ЗЦГ-аас хуулбарлан авсан картуудад хөдөлгүүрийн багтаамж, даац, суудлын тоо, бүх жин, өөрийн жин зэрэг гол гол үзүүлэлтүүд тавигдаагүй байсан. Тухайлбал аудитын тайлангийн төсөлд "...ачааны автомашин болон чиргүүлийн даац, трактор, өөрөө явагч хэрэгсэл, бага оврын трактор, тусгай зориулалтын автомашины хөдөлгүүрийн багтаамж зэргийг бүртгээгүй нийт 80.0 гаруй мянган тээврийн хэрэгсэл байна гэсэн нь дээрх байдалтай шууд холбоотой юм.

Бүртгэлийн санд тээврийн хэрэгслийн мэдээллийг оруулах явцад тодорхой бус мэдээллийг "1" гэж оруулсан бөгөөд ЗЦГ-аас хуулбарлан авсан 215195 тээврийн хэрэгслийн хартын мэдээллийг бүрэн бус бүртгэлийн санд оруулсан ба одоогийн байдлаар 187054 тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн багтаамж болон бусад мэдээллийг нөхөж оруулах, залруулах ажлыг хийгээд байна.

Энэ нь ЗЦГ-аас хуулбарлан авсан бүрэн бус мэдээлэлтэй тээврийн хэрэгслийн 86,9 хувийн бүртгэлийн санд залруулга, нэмэлт оруулсан бөгөөд өнөөдрийн байдлаар 13,1 хувь буюу 28041 тээврийн хэрэгслийн мэдээлэл нөхөгдөөгүй үлдээд байна.

**3.6, 3.31.** Тээврийн хэрэгслийн бүртгэлийн санг 2011 оны 5 сард ЗЦГ-аас цаасаар хуулбарлан авсан мэдээллийн хэмжээнд үүсгэж, улмаар 2011 оны 12

**ҮАГ-ын тайлбар  
2.1-ыг үзнэ үү**

**ҮАГ-ын тайлбар  
2.1-ыг үзнэ үү**

дугаар сар, 2012 оны 4 сард файлаар Татварын ерөнхий газарт хуулбарлаж өгсөн.

ТЕГ, АТГ газрын мэргэжилтнүүд хамтран техникийн болон програм хангамжийн түвшинд холболтын ажлыг шийдвэрлэсний дараа ТEG нь үйл ажилгаандаа шинэ систем нэвтрүүлж байгаа гэсэн үндэслэлээр 2012 оны 04 дүгээр сард тодорхойгүй хугацаагаар мэдээлэл солилцох үйл ажиллагааг хойшлуулсан ба хоёр байгууллагын хооронд сүлжээг энэ оны 7 дугаар сард багтаан холбохоор бэлтгэл ажлыг хийж байна. Одоогоор сүлжээнд холбогдоогүй байгаа хэдий ч ажлын уялдаа холбоог сайжруулах, харилцан мэдээлэл солилцох үүднээс ТEG-аас мэдээлэл хүссэн үед шаардлагатай мэдээллийн санг файл хэлбэрээр өгч байгаа ба тухайлбал, энэ оны 4 дүгээр сард мэдээллийг цахим хэлбэрээр хуулбарлаж өгсөн.

**ҮАГ-ын тайлбар  
2.2-ыг үзнэ үү**

**3.31.** Авто тээврийн газар нь нийт тээврийн хэрэгслийн мэдээллийн санг 2011 оны 11 сар, 2012 оны 04 сард электрон хэлбэрээр өмчлөгч болон өмнөх өмчлөгчийн мэдээллийн хамт ТEG-т хуулбарлан өгсөн. Хүргүүлсэн мэдээллийг ТEG нь өөрийн дүүргүүдийн татварын албадад өгөөгүйн улмаас 84466 тээврийн хэрэгслийн өмчлөгчийг бүртгээгүйн улмаас 2705,4 сая төгрөгийн татвар төлөгдөөгүй байгаа нь Авто тээврийн газартай холбогдолгүй болно. Мэдээлэл хүргүүлсний дараа холбогдох ажилтнуудаас шаардалага хангаж байгаа эсэхийг тодруулахад мэдээлэл хангалттай гэсэн хариулт өгч байсан.

**ҮАГ-ын тайлбар  
2.1-ыг үзнэ үү**

**3.7, 3.13.** ЗТБХБСайдын 2010 оны 19 дүгээр тушаалаар баталсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын 15.5-дахь заалтыг баримтлан тус газар нь тээврийн хэрэгслийг орон нутагт шилжүүлэх, улсын дугаар солих, тээврийн хэрэгслийн бусад үйлчилгээ үзүүлэхдээ тээврийн хэрэгслийн татварын гэрчилгээний хуулбарыг авч татвар төлсөн, эсэхийг шалгасны үндсэн дээр үйлчилгээ үзүүлж хэвшсэн болно.

Харин "Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт, зохицуулалтын алба" УТҮГ нь тээврийн хэрэгслийн нийслэлийн дүүрэг хоорондын шилжилт, орон нутгаас Улаанбаатар хотод шилжих хөдөлгөөн, мөн 21 аймаг хоорондын шилжилт хөдөлгөөнийг тус тус хариуцан гүйцэтгэж байгаа ба АТБӨЯХ-ийн албан татварын хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа эсэхэд манай газраас хяналт тавих боломжгүй юм.

**ҮАГ-ын тайлбар  
2.3-ыг үзнэ үү**

**3.15.** Авто тээврийн тухай хуулийн 6<sup>3</sup> дүгээр зүйл "Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн зхиргааны байгууллагын бүрэн эрх" -д

б<sup>1</sup> 1.3-т "Тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, холбогдох байгууллагыг байнгын мэдээллээр хангах"

б<sup>1</sup> 1.4-д "Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа автотээврийн хэрэгслийн бүртгэлийг хөтлөх" гэж хуульчилсан байна.

4

Гэтэл Авто тээврийн газрын хэрэгжүүлэх ёстой бүрэн эрхийг "Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт, зохицуулалтын алба" УТҮГ, түүний 21 аймаг дахь салбар давхар хэрэгжүүлж байгаа нь хуульд нийцээгүй төдийгүй уг заалтыг нэг мөр бүрэн хэрэгжүүлэх боломжгүйд хүргэж байна.

Ийнхүү Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан байгуулах ажлыг 2 байгууллага зэрэгцэн гүйцэтгэснээр тээврийн хэрэгслийн нэгдсэн сан байгуулах боломжгүй болж, статистик мэдээ, тайлан бодит байдалд нийцэхгүй зөрөх, ингэснээр төрийн байгууллагуудыг мэдээллээр хангах асуудал учир дутгалдтай болж, тээврийн хэрэгслийн улсын дугаарын давхардал үүсэх, нэгдсэн архив бүрдүүлэх зэрэг үйл ажиллагаанд хүндрэл учирч, тээврийн хэрэгслийн мэдээллийн сан, бүртгэлийн чанарт ахиц гарахгүй, хариуцлагыг бие бие рүүгээ түлхэж эзэнгүйдүүлэх зэрэг асуудал үүсч байна.

Иймд Автотээврийн газарт хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжийг олгож, Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан байгуулах ажлыг дангаар гүйцэтгэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

**3.18.** Тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй болгохын тулд "Да хүрээ" зах, "Хөсөг трейд" компаний байранд шинээр салбар нээн ажиллуулж байгаа боловч ажлын байрны багтаамж хүрэлцээгүй байна.

Авто тээврийн газар нь Тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлж, сайжруулах талаар дараах үр дүнтэй ажлуудыг хийгээд байна.

Тээврийн хэрэгслийн улсын дугаарыг хүний оролцоогүйгээр програмын аргаар олгох горимд бүрэн шилжүүлж нэг хүнд үйлчлэх хугацааг 5-10 минут болгосон ба иргэдэд аль болохоор хүндрэл чирэгдэл үүсгэхгүй ажиллах боломжийг бүрдүүлэхэд анхааран ажиллаж байна. Тухайлбал:

1.Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт, зохицуулалтын албатай VPN сүлжээгээр холбогдон, програм хангамжид зохих өөрчлөлтийг оруулсан. Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн багтаамж, даац, суудлын тоо, бүх жин, өөрийн жин зэрэг мэдээллүүдийг мэдээллийн санд залруулан оруулж тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон картанд хөдөлгүүрийн багтаамж, суудлын тоо, бүх жин, өөрийн жингийн мэдээллийг хэвлэж гаргадаг болсон.

2. ЗЦГ –аас хүлээж авсан 3111 тээврийн хэрэгслийн дугаарын давхардал байснаас одоогийн байдлаар нийт 3005 тээврийн хэрэгслийн дугаарын давхардлыг арилгасан бөгөөд үлдэж буй 106 тээврийн хэрэгслийн улсын дугаарын давхардлыг арилгахаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

**ҮАГ-ын тайлбар  
2.1-ийг үзнэ үү**



5

3. Тээврийн хэрэгслийг бүртгэх ажил нэгдсэн програмд шилжиж, гэрчилгээг гараар бичихийг зогсоож, програмаас хэвлэж эхэлснээр улсын дугаарын давхардал үүсэх нөхцөл бүрэн арилсан.

4. Газрын даргын 2012 оны А/035 тушаалаар Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд тус газраас олгож байгаа Тээврийн хэрэгслийн гэрчилгээ"-ний загварыг Замын хөдөлгөөний тухай олон улсын Конвенцид нийцүүлэн шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг загварын төслийг Конвенцийн 35.1.а-д заасан агуулгад нийцүүлэн боловсруулж холбогдох газруудаас санал авч ЗТБХБСайдад танилцуулахаар бэлтгэж байна. Гэрчилгээнд тээврийн хэрэгслийн бодит жин, ачаалалтай жин, хөдөлгүүрийн багтаамж, суудлын тоог тусгасан болно.

5. Замын цагдаагийн газрын дарга, Авто тээврийн газрын даргын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2012 оны А017/ 65 дугаар хамтарсан тушаалаар "Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг MNS44102002"-т өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, уг стандартад холбоотой дүрэм, журам, стандартад өөрчлөлт оруулах асуудлын талаар холбогдох байгууллагуудаас санал авлаа.

Мөн тропейбусыг дугааржуулах, тээврийн хэрэгслийн албан ёсны худалдааны төлөөлөгч байгууллагуудад замын хөдөлгөөнд оролцох "Түр дугаар" олгох болон "Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг MNS44102002"-т нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, хүнд даацын тээврийн хэрэгсэл, том оврын үйлдвэрлэлийн техникт технологийн тээврийн хэрэгслийн дугаар олгох асуудлыг шийдвэрлэж, Стандартчилал, хэмжил зүйн Үндэсний зөвлөлийн 2012 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 12 дугаар тушаалаар батлуулан мөрдөж эхлээд байна.

Стандартад орсон өөрчлөлттэй уялдуулан ЗТБХБСайдын 2010 оны 19 дүгээр тушаалаар баталсан "Тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулж холбогдох байгууллагуудаас санал авч ЗТБХБСайдад хүргүүлээд байна.

6. Авто тээврийн газрын даргын 2012 оны А/037 дугаар тушаалаар Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн архивын тооллого зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан ба тооллогыг энэ оны III улиралд хийж дуусгахаар ажиллаж байна.

АВТО ТЭЭВРИЙН ГАЗАР

### 3. Татварын ерөнхий газраас ирүүлсэн санал:



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**  
 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
 Нэгдсэн Үндэстний гудамж, Утас/Факс: (976-11) 32-76-86,  
 E-mail: info@mta.mn

2012.07.03 № 2а/1693  
 тандай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

Аудитын шалгалтын тайлангийн төсөлд өгөх тайлбар

Үндэсний аудитын газраас "Үл хөдлөх эд хөрөнгө, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар"-ын татвар төлөгчийн бүртгэл, татварын ногдуулалт, хураалтын хуулийн хэрэгжилт, хэржүүлж байгаа бодлого, хүрсэн үр дүнд хийсэн тайлангийн төсөлтэй танилцаж зарим нэг зүйлд дараах тайлбарыг хүргүүлж байна.

Үндэсний аудитын газрын тайлангийн 1.5-д "... мэдээллийн технологийн түвшин, хөгжил, чадвар сул..., мэдээллийн технологийг хариуцаж буй хүмүүсээс хэт хараат..., мэдээлэл ашиглалт, боловсруулалт өнөөгийн шаардлагад хүрэхгүй..." гэж дүгнэжээ. Энэ дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй бай Үүнд:

1. Татварын алба нь татвар төлөгчдөд хөнгөн шуурхай, ил тод, хүнд сурталгүй үйлчилгээ үзүүлэх зорилгоор төрийн байгууллагууд дотроос анх удаа 2003 онд "Нэг цэгийн үйлчилгээ", 2007 анх цахим тайлангийн систем, 2012 онд тоон гарын үсгийг ашиглан татварын тайланг ирүүлэх зэрэг үйлчилгээг нэвтрүүлсэн. Эдгээр үйлчилгээ нь мэдээллийн технологийн хамгийн сүүлийн үеийн технологи болох вэбэд суурилсан програм хангамж бүхий, бүх татварын албадтай шилэн кабелийн сүлжээгээр холбогдсон, мэдээллийн баазыг 30 минут тутам улсын хэмжээнд нэгтгэдэг мэдээллийн системээс шаардлагатай мэдээллийг бүх түвшний удирдлага, татварын улсын байцаагч нар ашиглаж байгаа зэргийг өнгөцхөн тооцоход мэдээллийн технологийн түвшин, хөгжил, чадвар сул гэдэгтэй санал нийлэхгүй байна. Татварын албаны мэдээллийн систем олон улсын өнөөгийн мэдээллийн технологийн хөгжилтэй зэрэгцэн хөгжиж байгааг салбарын дээд удирдлага болох Мэдээлэл шуудан, харилцаа холбоо, технологийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо болон бусад мэргэжлийн байгууллагууд үнэлдэг.

2. Татварын алба нь 2001 оноос эхлэн мэдээлэл боловсруулалт, ашиглалтын төвлөрсөн горимыг өөрчилж, татварын албаны хэрэглэгч өөрсдөө мэдээллийг боловсруулах, ашиглах төвлөрсөн бус тогтолцоог бий болгосон бөгөөд татварын албаны хэрэглэгч бүрт системд нэвтрэх эрхийг олгон, өөрсдийн үйл ажиллагаанд хамааралтай мэдээллийг мэдээллийн санд бүртгэн ашиглах боломж ямар ч шатны удирдлага, татварын албаны байцаагч нарт нээлттэй байгаагаас харахад татварын

S1455

ҮАГ-ын тайлбар  
 3.1-ийг үзнэ үү.

албаны мэдээллийн систем хариуцаж буй хүмүүсээс хэт хараат гэж харагдахгүй байна.

3. Татварын алба нь мэдээлэл боловсруулалт, ашиглалтыг бүрэн автоматжуулсан бөгөөд гараар боловсруулах үйл ажиллагаа буюу хүнээс хамаарсан үйл ажиллагааг үгүй болгосон билээ. Татварын хэрэглээний програм хангамжийн тусламжтайгаар татварын албаны үйл ажиллагаа автоматжуулсан мэдээлэл боловсруулалтын түвшинд явагддаг. Энэхүү мэдээллийн систем нь улсын хэмжээнд мөрдөж буй мэдээллийн технологийн салбарын хууль тогтоомж, стандарт, кодчиллын хүрээнд боловсруулагдсан бөгөөд тухай бүр шинэ хууль тогтоомж, журмын дагуу шинэчлэгдэж байдаг билээ. Иймээс мэдээлэл ашиглалт, боловсруулалт өнөөгийн шаардлагад хүрээгүй гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй байна. Ямар стандарт, шаардлагатай харьцуулж байгааг тодруулахыг хүсч байна.

ҮАГ-ын тайлбар  
3.2-ыг үзнэ үү.

4. Тайлангийн 1.21 д Импорт ороулж байгаа АТБӨЯХ ийн тоон үзүүлэлтийг татварын ногдуулалтын гүйцэтгэлтэй шууд харьцуулах замаар дүгнэлт хийх нь ерөөсгөл юм. Учир нь АТБӨЯХ ийн албан татварыг ногдуулахдаа АТБӨЯХ ийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу тухайн тээвэрт ногдох жилийн татварыг импорт ороулж ирсэнээс хойших хугацаанд бодож ногдуулдаг тул жилийн татварын хэмжээгээр ногдуулан харьцуулж болохгүй тул танилцуулгаас хасуулах саналтай байна. Харин Автотээврийн газарт байгаа АТБӨЯХ- ийн тоо нь импорт ороулж ирсэн гаалийн мэдээтэй эерж байгаа бол ГЕГ, АТГ хоёрын хооронд мэдээлэл солилцох ажиллагаа хангалтгүй байна гэсэн агуулгаар тодруулах саналтай байна.

ҮАГ-ын тайлбар  
3.3-ыг үзнэ үү.

5. Тайлангийн 2.51-д 19.2 сая төгрөгийн албан татвар ногдуулаагүй гэж бичжээ үүнд: Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хуулийн дагуу аж ахуйн нэгж болон иргэдийн өмчилж байгаа газарт албан татварыг "газрын алба ногдуулж, хураах ажлыг татварын алба" хийхээр хуульчилсан тул албан татварыг гэсний дараа "газрын алба" гэж засах.


ҮАГ-ын тайлбар  
3.4-ийг үзнэ үү.

6. 2.54, 2.55-ийн хувьд: Татварын ерөнхий газар нь татварын төрөл тус бүрээр үүссэн / сар, улирал, жилийн тайлан болон татварын хяналт шалгалтаар/ татварын өрийг ТӨХ –д заасан хэм хэмжээнд хураан барагдуулах ажиллагааг тогтмол хийж ирсэн. Татварын өрийн барагдуулалтын мэдээг сар бүр тусгай хүснэгтийн дагуу тогтмол авч дүгнэлт хийж удирдлагыг мэдээллээр хангахын зэрэгцээ татварын албадад зөвлөмж, чиглэлийг байнга өгч хэвшсэн болно. Эхний хагас жилийн байдлаар урьд оны өрийн үлдэгдэлийн 81.0 хувийг буюу 288.8 тэрбум төгрөгийг, энэ оны тайлангийн өрийн 86.2 хувийг буюу 492.9 тэрбум төгрөгийг барагдуулаад байна.

ҮАГ-ын тайлбар  
3.5-ыг үзнэ үү.

7. Тайлангийн 2.33, 2.34, 2.41, 2.48, 2.49 дэх дүгнэлтийг зөвшөөрөх боломжгүй байна. Татварын алба нь Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хуулийг хэрэгжүүлэх үүднээс 2001 оноос ҮХЭХ-ийн бүртгэлийн сан үүсгэн ашиглаж байгаа бөгөөд 2004, 2007 онуудад ҮХЭХ-ийн тооллого явуулж нуугдмал орлогыг илрүүлэх арга хэмжээнүүдийг байнга авч хэрэгжүүлдэг. УБЕГ-ын ЭХЭУБГ-с авсан үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн сан нь татвар ногдох ҮХЭХ болон татвар ногдохгүй ҮХЭХ-ийг ялгаж бүртгэдэггүй, нэг объект дээр хэд хэдэн аж ахуйн нэгж, иргэний бүртгэсэн, орон сууцны зориулалттай хөрөнгийг аж ахуйн нэгж, иргэн ашиг олох

зорилгоор ашиглаж байгаад үйл ажиллагаагаа зогсоож орон сууцны зориулалтаар ашиглаж байгааг зэрэг үйлдлийг ялгаж салгахгүйгээр бүртгэж шаардлага хангаагүй мэдээлэл ирүүлдэг. Аудитын тайланд дурьдсан дээрх заалтуудыг хүлээн зөвшөөрөх боломжгүй байгаа бөгөөд дахин нягтлан үзэх шаардлагатай гэж үзэж байна.



**Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн саналд өгөх тайлбар****ҮАГ-ын тайлбар 1.1**

Саналыг хүлээн авч тайлангийн 2.7 дах заалтыг хасав.

**ҮАГ-ын тайлбар 1.2**

Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

**ҮАГ-ын тайлбар 1.3**

"ЭХӨЭТХЭХБЭУБТухай хуулийн 18.2-т бүртгэлийн гэрчилгээнд ерөнхий болон улсын бүртгэгч, орон нутагт улсын бүртгэгч гарын үсэг зурж, тэмдэг дарна гэж заасан боловч бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотой УБ хот дахь бүртгэлийн үйл ажиллагаа дүүргүүдэд шилжсэнээр бүртгэлийн гэрчилгээний баталгаажуулалт УБЕГ-т төвлөрч цаг хугацаа их орж, чирэгдэл бий болгож буйг зохицуулах шаардлагатай байна." гэж өөрчлөн найруулав.

**ҮАГ-ын тайлбар 1.4**

Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

**ҮАГ-ын тайлбар 1.5**

Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

**ҮАГ-ын тайлбар 1.6**

Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

**Автотээврийн газраас ирүүлсэн саналд өгөх тайлбар****ҮАГ-ын тайлбар 2.1**

Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

**ҮАГ-ын тайлбар 2.2**

Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

**ҮАГ-ын тайлбар 2.3**

Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

**Татварын ерөнхий газраас ирүүлсэн саналд өгөх тайлбар:****ҮАГ-ын тайлбар 3.1**

Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

**ҮАГ-ын тайлбар 3.2**

Саналыг хүлээн авч "... хийгдээгүй, ГЕГ, АТГ хоорондын мэдээлэл солилцоо, тэдгээрийн ашиглалт хангалтгүй байгааг харуулж байна" гэж өөрчлөв.

**ҮАГ-ын тайлбар 3.3**

Саналын дагуу "... албан татварыг газрын албадаас ногдуулаагүй байна" гэж найруулгын өөрчлөлт хийв.

**ҮАГ-ын тайлбар 3.4**

Тайлангийн 2.54-т "... дотоод хяналтын тогтолцоо Татварын албадад иж бүрэн үйлчлэхгүй байна" гэж нэмж оруулав.

**ҮАГ-ын тайлбар 3.5**

Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

## **Зөвлөмж**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

### **Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Л.Амарсанаад:**

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын Үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн асуудал хариуцсан тасаг нэгжүүдийн ажил, үйлчилгээний зохион байгуулалт, дотоод хяналтыг сайжруулж, иргэдэд чирэгдэлгүй, шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх,
- Хууль болон “Мэдээлэл солилцох журам”-ын хэрэгжилтийг хангах, татварын байгууллагыг мэдээллээр хангах, ажлын уялдааг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- Архив, бүртгэлийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээ авах.

### **Авто тээврийн газрын дарга П.Дэлгэрнарнд:**

- Автотээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтыг сайжруулж, бүрэн хамруулах арга хэмжээ авах,
- Татварын ерөнхий газрыг үнэн зөв, найдвартай мэдээллээр бүрэн хангах талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх,

### **Татварын ерөнхий газрын дарга Б.Баттөмөрт:**

- Үл хөдлөх эд хөрөнгө, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүх төрлийн албан татвар, төлбөрийн ногдуулалт, хураалтын үйл ажиллагааг хөнгөн шуурхай, зохион байгуулалт сайтай, үр нөлөөтэй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- Нийслэл, дүүргийн татварын албадын албан татварын ногдуулалт, хураалтын ажлын үр нөлөөг дээшлүүлэх, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- Хяналтыг сайжруулж, бүртгэлд бүрэн хамруулах замаар татварын бааз, суурийг өргөтгөх арга хэмжээ авах,

### **Хууль зүй, дотоод хэргийн, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын болон Сангийн сайд нарт:**

- Нийслэл, орон нутгийн төсөвт төвлөрүүлж буй тайланд дурдагдсан 2 төрлийн татвар төлөгчийн анхан шатны бүртгэл, шилжилт хөдөлгөөн, мэдээлэл солилцоо, татварын ногдуулалт, хураалтын үйл ажиллагаанд гарч буй алдаа дутагдлыг арилгуулах талаар агентлаг, газруудын ажлын уялдааг хангах, мэдээллийн технологийг эрчимтэй нэвтрүүлэх, ажил үүргийг тодорхой болгох эрх зүйн орчныг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, зөрчил гаргаж буй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож байх.

**ӨМНӨХ АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Нийслэлийн аудитын газраас “Үл хөдлөх эд хөрөнгө, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын бүрдүүлэлтэд 2010 онд аудит хийж холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөмж өгчээ. Хэрэгжилт дутуу болон хангалтгүй хэрэгжилттэй зөвлөмжийг үзүүлбэл:

Хэнд хандсан:	Зөвлөмжийн агуулга:
Автотээврийн газрын дарга:	<ul style="list-style-type: none"> <li>Тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрэн бүрдүүлэх, холбогдох байгууллагыг байнгын мэдээллээр хангах хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх.</li> </ul>
Татварын ерөнхий газрын дарга:	<ul style="list-style-type: none"> <li>Гаалийн ерөнхий газар, Автотээврийн газар, Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт зохицуулалтын албадаас автотээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, шилжилт хөдөлгөөний мэдээллийг хууль, журамд заасны дагуу шахаж шаардаж хүлээн авч орон нутгийн татварын албадыг мэдээллээр цаг хугацаанд нь бүрэн хангах.</li> </ul>
Нийслэлийн татварын газрын дарга:	<ul style="list-style-type: none"> <li>Татварт хамрагдаагүй автотээврийн хэрэгслийг бүрэн хамруулах арга хэмжээ авах, дүүргүүдийн тээврийн хэрэгслийн татвар хариуцсан албадад тавих хяналтын сайжруулах.</li> </ul>
Дүүргийн татварын албаны дарга нарт:	<ul style="list-style-type: none"> <li>Нийслэлд эзэмшигч нь харъяалалтай бөгөөд автотээврийн хэрэгслийн албан татварыг аймаг, орон нутагт төлсөн жагсаалт гарган Татварын ерөнхий газар, Нийслэлийн татварын газарт хүргүүлж, нийслэлийн төсвийн орлогол оруулах асуудлыг шийдвэрлэх.</li> <li>Дүүргийнхээ харъяа автотээврийн хэрэгслийг бүрэн бүртгэж татварт хамруулах, автотээврийн хэрэгслийн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэлийг цэгцэлж үнэн зөв мэдээлэл, бүртгэлтэй болох,</li> </ul>
Нийслэлийн татварын газрын дарга:	<ul style="list-style-type: none"> <li>Нийслэлийн төсвийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж, төсвийн сахилга зөрчсөн дүүргийн татварын хэлтсийн зарим удирдлагуудад ажлын хариуцлага тооцох, дээрхи зөрчлийг таслан зогсоох, сонирхолын зөрчилтэй албан тушаалтныг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх.</li> </ul>
Дүүргийн татварын албаны дарга нарт:	<ul style="list-style-type: none"> <li>Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг бодит байдалд нийцүүлэн үнэн зөв болгох талаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар болон холбогдох бусад байгууллагуудаас үнэлгээг 2010 оны 6-7 дугаар сард багтаан авч татвар төлөгчдийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг үнэн зөв болгох ажил зохион байгуулж үр дүнг тооцох.</li> <li>Татварын бүртгэлийг улам сайжруулж илүү, дутуу төлөлтийн хэмжээг өмнөх жилүүдээс бууруулах, дутуу төлөлтөнд хуулийн дагуу хоногийн хүү тооцож татварын орлогын биелэлтэд тавих дотоод хяналтаа сайжруулах.</li> </ul>

1. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг зохих журмын дагуу бүрэн бүрдүүлж буй эсэхэд хийсэн аудитаар НАГ-аас өгсөн нийт 21 зөвлөмжөөс бүрэн хэрэгжсэн 3, бусад зөвлөмжийн хэрэгжилт 60.0 гаруй хувьтай хэрэгжсэн байна.
2. Харин үл хөдлөх эд хөрөнгийн албан татвартай холбоотойгор өгсөн 8 зөвлөмжөөс хэрэгжих шатандаа 5, хэрэгжээгүй 3 буюу хэрэгжилт 62.5 хувьтай байжээ.





**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ**

2012 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 77

Улаанбаатар хот

**Аудитын тайланг баталгаажуулах тухай**

"Төрийн аудитын тухай хууль"-ийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Үл хөдлөх эд хөрөнгө, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүх төрлийн албан татвар ногдуулалт, хураалтын бодлого, үр дүн"-д хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Улсын бүртгэлийн ерөнхий газар, Автотээврийн газар, Татварын ерөнхий газруудад, Хууль зүй, дотоод хэргийн, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын, Сангийн сайд нарт хүргүүлсүгэй.

Гурав. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг 2012 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн сайд Д.Хаянхярваа, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайд Ц.Дашдорж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Л.Амарсанаа, Автотээврийн газрын дарга П.Дэлгэрнаран, Татварын ерөнхий газрын дарга Б.Баттөмөр нарт зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Ч.РАДНАА

070202